



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ**

**ӨЛЗИЙНЭМЭХ**  
Зориг ЭНГҮН

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**  
**ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХ ЗАЛГАМЖЛАХ**  
**АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ**



Мэргэжлийн индекс  
041301

Эрх зүйн бакалаврын  
Зэрэг горилсон  
Дипломын төсөл

Удирдсан  
Б.Хэрлэнчимэг /LL.C/

Улаанбаатар. 2025



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**

**ӨЛЗИЙНЭМЭХ**  
**Зориг ЭНГҮН**

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН**  
**ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЭРХ**  
**ЗАЛГАМЖЛАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ**  
**АСУУДАЛ**



Мэргэжлийн индекс  
041301

Эрх зүйн Бакалаврын Зэрэг  
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : . . . . . Б. Хэрлэнчимэг \LL.M\

Шүүмж : . . . . . Ц.Даваасүрэн \LL.M\

## **ГАРЧГИЙН ТОВЬЁГ**

МЭДЭГДЭЛ .....	3
ТАЛАРХАЛ.....	4
ТОВЧ ХУРААНГУЙ.....	5
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	7
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	9
НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР .....	10
ОРШИЛ .....	12
Сэдвийн үндэслэл .....	13
Сэдвийн зорилго, зорилт.....	13
Сэдэв судлагдсан байдлын судалгаа.....	14
Сэдвийн тулгамдсан асуудал.....	14
Судалгааны ажлын арга зүй .....	14
Судалгааны ажлын шинэлэг тал .....	14
Судалгааны ажлын ач холбогдол .....	15
I БҮЛЭГ. Онолын судалгаа .....	15
СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ .....	16
1.1 Эрх залгамжлах ажиллагаан дахь эрх зүйн харилцаа, түүний ойлголт .....	16
1.1.1 Эрх залгамжлах ажиллагаан дахь эрх зүйн харилцаа, түүний ойлголт .....	26
1.1.2 Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сураггүй алга болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэх.....	28
1.1.3 Хуулийн этгээд хянан шийдвэрлэх ажиллагааны татан буугдах тохиолдолд хэрхэн шийдвэрлэх.....	28
1.1.4 Шаардлага болон үүргээ зохигч хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шилжүүлэх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх .....	28
1.2 Эрх залгамжлагчийг солих .....	28
1.2.2 Зохигч, сонирхогч этгээлийн хүсэлтийн дагуу эрх залгамжлагчийг солих талаар .....	28

1.2.3 Эрх залгамжлах ажиллагаан дахь бүх эрхийг эдэлж үүргийг хүлээх талаарх ойлголт.....	28
1.3 Эрх залгамжлах ажиллагаатай ойролцоо ойлголтоос ялгах нь.....	28
1.3.1 Эрх залгамжлах ажиллагаа болон өв залгамжлах ажиллагаа буюу ойролцоо ойлголтоос ялгах нь.....	28
1.3.2 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх залгамжлах ажиллагааны зарим асуудлыг тухайн хуулийн 28 дүгаар зүйлээс ялган тайлбарлах нь .....	28
II БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ .....	28
2.2.1 Англо саксон эрх зүйн бүлийн улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх залгамжлах ажиллагааны талаар (АНУ-ын жишээн дээр тайлбарлах нь) .....	28
2.2 Ром-Германы эрх зүйн бүлийн улсуудын эрх залгамжлах ажиллагааны харьцуулсан судалгаа .....	28
2.2.1 Япон Улс.....	28
2.2.2 БНСУ.....	28
2.2.3 БНХАУ .....	28
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ .....	28
3.1 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	28
3.2 Эрх залгамжлалын зохицуулалтын хэрэгжилтийн судалгаа: Асуумжийн судалгааны үр дүн .....	28
ДҮГНЭЛТ.....	28
ЗӨВЛӨМЖ.....	28
НОМ ЗҮЙ.....	28
ХАВСРАЛТ.....	28

## МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төсөл өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (сэзис) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (cc by-nc-nd) 3.Энгүн лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: З.Энгүн

Гарын үсэг:

Огноо: 2026/./..

## ТАЛАРХАЛ

Бакалаврын дипломын төсөл бичихэд удирдсан багш Б.Хэрлэнчимэг, зөвлөсөн шүүмжлэгч багш Ц.Даваасүрэн, зөвлөсөн хүмүүс, хамтран ажилласан байгууллагад мөн СЭЗИС-ийн эрх зүйн тэнхимийн хамт олонд талархал илэрхийлье.

## ТОВЧ ХУРААНГУЙ

Иргэний эрх зүйн харилцаанд оролцож буй талуудын нэг нь маргаантай харилцаанаас гарсан тохиолдолд түүний процессын эрх, үүргийг хуульд заасан үндэслэлээр өөр этгээдэд шилжүүлэхийг эрх залгамжлал гэнэ.

Энэ ойлголт нь хэрэг маргаан шийдвэрлэгдэх явцад зохигч болох иргэн нас барах, сураггүй алга болсонд тооцогдох, хуулийн этгээд татан буугдах, мөн үүрэг, шаардлагыг бусдад шилжүүлэх зэрэг тохиолдлууд ордог ба маргаанд оролцогчийн эрх, үүрэг нь тодорхой нөхцөл байдлын улмаас өөр этгээдэд шилжсэн бол түүний шүүхэд эдлэх процессын эрх, хүлээх үүрэг мөн адил дагалдан шилждэг тул материаллаг эрх зүйн харилцаатай шууд холбоотой мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд үүсэх боломжтой гэдгээрээ онцлогтой.

Гэхдээ эрх залгамжлах ажиллагаа явагдлаа гээд тухайн этгээдийн бүх эрх, үүрэг бүрэн шилжинэ гэж ойлгож болохгүй. Зарим эрх нь тухайн хүний өөрийнх нь хувийн шинжтэй шууд холбоотой байдаг. Жишээлбэл, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, тэтгэлэг гаргуулах зэрэг асуудал нь өөр этгээдийн биелүүлэх ёстой үүрэг гээд шилжүүлэх боломжгүй тул эрх залгамжлалд хамаарахгүй. Мөн эрх залгамжлагч нь заавал анхны маргааны оролцогч байсан байх албагүй байдаг. Эрх залгамжлалын үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилдэг бол нэхэмжлэгч, хариуцагчийг сольсон тохиолдолд тухайн ажиллагааг дахин эхлүүлэх шаардлага гардаг. Энэ нь хоёр ойлголтыг ялгах чухал үндэс болдог.

Энэхүү судалгаагаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлал хэрхэн үүсэж, практикт ямар асуудлууд гарч байгааг онолын хүрээнд болон практик дээр Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн Иргэний хэргийн Анхан шатны шүүх, Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргын шүүх дээр асуумжийн аргаар судлан авч үзлээ. Судалгаанаас харахад эрх залгамжлал үүсэх хамгийн түгээмэл шалтгаан нь зохигч нас барах явдал байна. Мөн шүүхийн практикт холбогдох хуулийн буюу ИХШХШТХ-ийн 80, 113 дугаар зүйл заалтуудыг хамтад нь хэрэглэж байгаа нь ажиглагдсан.

Үүнээс гадна эрх залгамжлалтай холбоотой зарим нарийн асуудлууд хуульд тодорхой тусгагдаагүй хэвээр байгаа нь шүүхийн шийдвэрүүд болон асуумжийн аргаар авсан судалгааны үр дүнд харагдсан.. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацаа, нас барсан этгээдийг төлөөлөх асуудал, эрх залгамжлагчийн хариуцлагын хэмжээ зэрэг нь илүү тодорхой зохицуулалт шаардлагатай харагдаж байна. Мөн хуулийн этгээд татан

буугдсан ч эрх залгамжлагчгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох нь зарим тохиолдолд иргэдийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байна.

Судалгааны хүрээнд гадаадын зарим улс, тухайлбал АНУ, Япон, Хятад, Солонгос улсын эрх залгамжлах ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзсэн бөгөөд энэ нь Монгол Улсын хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгоход ач холбогдолтой гэж үзлээ

**Түлхүүр үгс:** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, эрх залгамжлал

## **ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

### **ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1.1 Эконометрик загвар үндэслэн Монгол улсын макро эдийн засгийн стратеги төлөвлөлт хийх арга зүйн асуудлууд .....	2
--	---

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ****Товчлол****ИХШХШТХ****ИХШХША****УДШ****ИХ****Тайлбар**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх  
тухай хууль

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх  
ажиллагаа

Улсын дээд шүүх

Иргэний хууль

**НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР****Нэршил****Тайлбар****Эрсдэлийн удирдлага**

Тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд эрсдэлийг тодорхойлох үе шат нь байгууллагын зорилгоос шалтгаалан ялгаатай байна.



## **ОРШИЛ**

### **Сэдвийн үндэслэл**

Монгол Улсын эрх зүйн тогтолцооны гол зорилго нь оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, шударга шийдвэр гаргах явдал байх ёстой. Энэ нь онол дээр буюу материаллаг хууль дээр тодорхой боловч практикт хэрэгжихдээ хүндрэлтэй байдаг нь анзаарагддаг. Ялангуяа хууль хоорондын уялдаа, хэрэгжилт нь хэрэгждэггүй нь практикт харагдаж байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудтай холбоотой өөрчлөлт гарах нь байдаг. Жишээ нь, иргэн нас барах, эсвэл хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэрэг. Ийм үед тухайн этгээдийн эрх, үүргийг хэн үргэлжлүүлэх вэ гэдэг асуулт гарч ирдэг. Энэ үед эрх залгамжлал гэдэг ойлголт практикт хэрэг болдог.

Эрх залгамжлал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоохгүй үргэлжлүүлэхэд чухал оролцоотой ойлголт юм. Мөн талуудын эрх ашгийг аль болох хамгаалах нөхцөл бүрдүүлэх үүрэгтэй. Гэхдээ хэрэгжүүлэхэд зарим асуудал бий болдог. Жишээ нь, Хэрэг дээр эрх залгамжлагчийг оролцуулах үйл явц удааширч, хугацаанд нөлөөлөх зэрэг ажиглагддаг. Мөн үүнээс болоод бусад зохигчдын процессын эрх хөндөгдөх нөхцөл ч үүсч болно.

Иймээс эрх залгамжлалын зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлага байна гэж харагддаг. Үүнийг онолын хувьд ч, практикт тулгуурлан ч судлах нь зүйтэй гэж үзсэн. Мөн шүүхийн практикт нэг мөр ойлголт бий болгох шаардлагыг анзаарсан. Ингэж чадвал иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа илүү ойлгомжтой, шуурхай, шударга болох боломжтой хэмээн судласан оюутны зүгээс дүгнэлээ.

### **Сэдвийн зорилго, зорилт**

Монгол улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны процессын дунд гардаг эрх залгамжлах ажиллагааны зарим асуудлыг хууль зүйн практик болон онолын үүднээс судлан дүн шинжилгээ хийж бусад орны хууль тогтоомжийн хэрэгжилтэд үндэслэн харьцуулж судлаачийн дүгнэлт, санал дэвшүүлэх зорилгын хүрээнд судалгааны ажлаа бичихийг зорилоо.

Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлалын эрх зүйн мөн чанар, онолын үндсийг тодорхойлох, ИХШХШТХ-ийн 28 дугаар зүйл буюу “Нэхэмжлэгч, хариуцагчийг солих” ойлголтоос ялган тайлбарлах
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн эрх залгамжлалтай холбоотой зохицуулалтыг судлан, эрх ба үүргийн шилжилтийн хууль зүйн онцлог, процессыг шинжилж дүгнэх.
3. Эрх залгамжлах ажиллагааны бодит хэрэгжилт, шүүхийн практикт тулгамдаж буй асуудал, зөрчлийг илрүүлэх, задлан шинжлэх.
4. Бусад улс орнуудын эрх зүйн тогтолцоонд эрх залгамжлалын асуудлыг хэрхэн зохицууж байгааг судлан, Монгол улсын хуультай харьцуулан дүгнэлт гаргах.

### **Сэдэв судлагдсан байдлын судалгаа**

Эрх залгамжлал сэдвийн судалгааны хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх залгамжлах ажиллагааны тухай Улсын дээд шүүхийн “Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” 2009 он ном, сурах бичиг, Холбогдох харьцуулсан судалгааны тухай Шүүхийн судлагааны төвийн “ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлд холбогдох судалгаа” 2023 он, Их Засаг Олон Улсын Их Сургууль, Хууль зүйн сургуулийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хэрэглээ, дадлага” 2004 он ном, сурах бичгүүд болон судалгааны ажлыг голчлон эх сурвалжаар ашиглалаа.

### **Сэдвийн тулгамдсан асуудал**

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд нас барах, сураггүй алга болох, хуулийн этгээд татан буугдах, нэгдэх, шилжих зэрэг шалтгаанаар түүний эрх, үүргийг өөр этгээдэд шижүүлэх шаардлага бодит практикт гарсаар байна. Энэ тохиолдолд эрх залгамжлах ажиллагааны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх хугацаа хойшлогдож, түдгэлзсэнээр хэргийн бусад оролцогчдын цаг хугацаа, эрх ашиг ил болон далд зөрчигдсөөр байна.

### **Судалгааны ажлын арга зүй**

Уг сэдвийг судлахдаа баримт бичгийн судалгааны арга, харьцуулан шинжлэх, анализ, асуумжийн аргаар судалгаа хийх зэрэг аргуудыг ашигласан болно. Мөн дипломын ажлын хүрээнд тус сэдэвтэй хамааралтай бүхий л баримт, холбогдох эрх зүйн эх сурвалж, эрдэмтэн судлаачдын бүтээлд суурилан бичсэн онол, практикийн ач холбогдолтой гэж үзэж байна.

### **Судалгааны ажлын шинэлэг тал**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан эрх залгамжлах ажиллагааны зарим асуудал практик болон хууль эрх зүйн талаас зохигчид болон шийдвэрт хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгааны ажил бичих нь тухайн сэдвээр хэрэг маргаанд тулгамдаж болзошгүй асуудлаас сэргийлэн хугацааг хэмнэх, тус сэдвийн хүрээнд баримт бичгийн судалгаа, статистик судалгаа, эрх зүйн шинжилгээ болон анализ синтцзийн аргуудыг ашиглан бичсэнээр энэ чиглэлээр судалгаа хийж буй хэн бүхэнд ашиглах боломжтой эх сурвалж болно.

### **Судалгааны ажлын ач холбогдол**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах ажиллагаа орж ирсэн ч хэрэгт оролцож буй бусад зохигчдын цаг хугацаа, эрх ашгийг хамгаалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ач холбогдолтой.

## I БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА

### СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

#### 1.1 Эрх залгамжлах ажиллагаан дахь эрх зүйн харилцаа, түүний ойлголт

Онолын ойлголт:

Хүснэгт 1. 1 Эрх залгамжлал үгийн бүтцийн тайлбар

Үг	Тайлбар
Эрх	<p>Эрх гэдэг нь <u>англи</u> хэлэнд “human rights” , <u>орос</u> хэлэнд “права человека” үгнээс гаралтай ба үгийн утгын хувьд анх шулуун буюу зөв чиглэл гэсэн утга илэрхийлдэг байсан нь явсаар ёс суртахуун, хууль эрх зүйн хувьд "зөв, шударга, эрхэмлэх зүйл" болж хөгжсөн түүхтэй<sup>[1]</sup>. Монгол улсын үндсэн хуульд<sup>[2]</sup> заасны дагуу амьд явах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох гэх мэтчилэн 18 эрх байдаг ба материаллаг эрх зүйн хөдөлмөрлөх, эзэмших, өмчлөх эрхүүд, процессын эрх зүйн шүүхийн шийдвэрт гомдол гаргах, хариу тайлбар өгөх гэх мэтчилэн эрхүүд яригдахаас эрх залгамжлах ажиллагаа нь ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлд заасны дагуу процессын эрхүүд болох тухайн ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заагдсан 8 эрх мөн материаллаг эрх зүйн шаардах эрх гэх мэтчилэн эрхүүд залгамжлагдаж байгаа юм.</p>
Залгамжлал	<p>Залгамжлал гэдэг нь Монгол хэлэнд “Залгамж - Нэгэн хэрэг явдал, үйл ажиллагааны үргэлжлэл”; Англи хэлэнд “Succession [n] - 1. Дэс дараалал, 2. Залгамжлах үйл явц (эрх залгамжлал)”, Латин хэлэнд succedere [v] (хойшоо суух, дараа нь орох, залгамжлах) гэдэг үйл үгээс гаралтай<sup>[3]</sup>.</p> <p>Материаллаг болон процессын эрхүүдийг тусгай байгууллагын хамааралтайгаар буюу зөвшөөрөл олгогдсоны үндсэн дээр эрхтэй этгээд залгамжлах ойлголт юм.</p>

Эх сурвалж: <https://mongoltoli.mn/>

Эрх залгамжлах эрхийн онол нь Ромын эрх зүйн “Суксэсио универсалис<sup>[1]</sup>” ойлголтоос үүдэлтэй. Энэ нь хөрөнгө, өр төлбөр, нэхэмжлэлийг бүхэлд нь шилжүүлэх Ромын зарчим байсан бөгөөд цаг хугацааны явцад Ром-Германы эрх зүйн тогтолцоонд нэгдэж, улмаар ЗХУ-аар дамжин Монгол улсын эрх зүйн тогтолцоонд өв залгамжлал болон шүүн таслах ажиллагаанд оролцох эрхээр эхлэн нэвтэрсэн ба 1960 болон 1992 оны дараагаар 2002 оны Иргэний хуульд тусгагдсан байна. Энэ ойлголт нь Монголын иргэний хуульд ардчилсан шинэчлэл болон 1992-ээд оны зах зээлийн шилжилтийн үеийн дараагаас орж ирсэн.

Монгол улсад 1994–2002 оны хооронд ардчилсан нийгэмд шилжсэний дараа эрх залгамжлах ойлголт нь бүрэн хуульчлагдсан ба энэ нь эрх зүйн хувьд тэгш байдал, шударга ёсыг хамгаалах эрх зүйн механизм болох үндэслэл нь тавигдсан байгаа юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргаантай эрх зүй үүсэж үүнээс зохигч гарах буюу солигдож болдог бөгөөд үүний нэг тохиолдол нь эрх залгамжлах ажиллагаа ба эрх залгамжлах, эрх залгамжлан авах ажиллагааны утга нь хэргийн оролцогчийн эрх үүрэг өөр этгээдэд шилжихэд оршино<sup>[1]</sup>. Ийнхүү эрх үүргийг шилжүүлэн авсан этгээд иргэний хэргийн оролцогчийн эрх залгамжлагч болдог.

Гэвч үүргийн харилцаанд шинэ этгээд нэмэгдэн орох үйл явдал нь эрх залгамжлагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах шууд үндэслэл болоод байдаггүй. Ийнхүү шинэ этгээд үүргийн нэмэгдсэн ба хуучин эрх эзэмшигч эсхүл үүрэг гүйцэтгэгч шинэ этгээдэд эрх, үүргээ шилжүүлсэн тохиолдолд л эрх залгамжлагчийг ИХШХШ тухай хуульд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно<sup>[2]</sup>.

*Хүснэгт 1. 2 Эрх залгамжлал үгийн бүтцийн тайлбар*

Эрх залгамжлал үүсэх үндэслэлүүд	
Хүн нас барсан	ИХ-ийн 24 <sup>[1]</sup> дүгээр зүйлд зааснаар зохигч иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр гарсан тохиолдлууд.
Сураггүй алга болсонд тооцогдсон	ИХ-ийн 23 <sup>[2]</sup> дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу зохигч этгээдийг сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүнийг эрх залгамжлан авагчаар сольж болно.

Хуулийн этгээд татан буугдсан	ИХ-ийн 32 <sup>[3]</sup> дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу хэргийн зохигч хуулийн этгээд татан буугдсан бол түүний эрх залгамжлагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болно.
Шаардага ба үүргээ бусдад шилжүүлсэн	Хэргийн зохигч тухайн иргэний хэрэг шийдвэрлэгдэж байгаа маргаан дахь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрх эсхүл гүйцэтгүүлэгчийн үүргээ бусдад шилжүүлсэн бол шаардах эрх, эсхүл үүргийг шилжүүлж авсан этгээдээр зохигчийг сольж болно. ИХ-ийн 123,124 <sup>[4]</sup> дүгээр зүйлүүдэд заасны дагуу шаардах эрх, өр шилжсэн тохиолдлууд хамаарна.

Эх сурвалж: *Legalinfo.mn*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлаж байгаа тохиолдолд хэргийн оролцогчийн эдлэх бүх эрх, үүрэг эрх залгамжлагчид шилждэг ба зарим эрх үүрэг шилжих боломжгүй ба эрх залгамжлал хийгдэхгүй байх тохиолдол ба онцлогын талаар дурдъя:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлал зөвхөн материаллаг эрх зүйн харилцаанд үүсэх боломжтой. Энэ үед ИХ-ийн 240 дугаар зүйлийн 240.1.2<sup>[1]</sup>, 240.1.3<sup>[2]</sup> заалтууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

1. ИХ-ийн 240 дугаар зүйлийн 1.2 дахь заалт Үүргийн гүйцэтгэл үүрэг гүйцэтгэгчийн хувийн байдалтай салшгүй холбоотой тохиолдолд үүрэг гүйцэтгэгч иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон, түүнчлэн нас барсан гэж зарлагдсан бол үүрэг дуусгавар болно.
2. ИХ-ийн 240 дугаар зүйлийн 1.3 дахь заалт Үүрэг гүйцэтгэл нь гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгчид хамааралтай тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон, түүнчлэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан бол үүрэг дуусгавар болно.

Гэвч материаллаг эрх зүйн бүх харилцаанд эрх залгамжлал явагдаж болно гэсэн утга биш ба процессын эрх залгамжлалд хувийн эрх шинжтэй үүрэг шилждэггүй<sup>[3]</sup>.

Жишээ нь:

Хариуцагч А нас барвал түүний тэтгэлэг төлөх үүрэг бүр мөсөн дуусгавар болно. Энэ үүрэг нь хувийн шинжтэй тул өв залгамжлагч, өмгөөлөгч, эсвэл бусад этгээдэд

шилжихгүй. Гэр бүлийн тухай хуулийн 38<sup>11</sup> дугаар зүйлд үндэслэсэн эцэг эх, хүүхдээ тэжээн тэтгэх энэ үүрэг нь зөвхөн нас барсан этгээдийн амьдралын хугацаанд үйлчилнэ. Шүүх ийм тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 1.10 зүйлд заасны дагуу захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Зохиогчийн хувийн эрх / нэр, нэр хүнд, бүтээлийг өөрчлөхгүй байх гэх мэт / нас барсан зохиогчийн өв залгамжлагчид шилжихгүй. Зөвхөн эдийн засгийн эрх буюу орлого олох тохиолдолд шилждэг ба эрх залгамжлал хийгдэх үндэслэлүүдийг дараагийн дэд бүлгүүдээр дэлгэрүүлэн авч үзье.

### **1.1.1 Эрх залгамжлах ажиллагаан дахь эрх зүйн харилцаа, түүний ойлголт**

**Тодорхойлолт:** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигч талуудын аль нэг нь нас барах, эсхүл нас барсанд тооцогдох нь процессын эрх залгамжлал үүсэх нөхцөл болдог.

Иргэний хуулийн 24<sup>11</sup> дүгээр зүйлд заасны дагуу шүүх дараах үндэслэлүүдээр иргэнийг нас барсанд тооцож болно. Үүнд:

1. Ердийн нөхцөл: Иргэн оршин суугаа газраасаа сураггүй алга болсноос хойш 5 жилийн хугацаанд түүний байгаа газар нь мэдэгдэхгүй, амьд байгаа эсэх нь тогтоогдохгүй бол.
2. Амь насанд аюултай нөхцөлд орсон: Иргэн амь насанд нь аюул учруулж болох нөхцөл байдалд / жишээ нь: гал түймэр, үер, нуранги гэх мэт / алга болсон бөгөөд түүнээс хойш 6 сарын турш сураг чимээгүй бол.
3. Гэнэтийн аюул, осолд орсон: Тодорхой гэнэтийн аюулын / жишээ нь: онгоцны осол, сүйрэл гэх мэт / улмаас алга болсон бол тухайн үйл явдлаас хойш 6 сар өнгөрсний дараа нас барсанд тооцож болно.
4. Цэргийн ажиллагааны үеэр: Дайны болон цэргийн ажиллагаанд оролцож байгаад сураггүй болсон иргэнийг цэргийн ажиллагаа дууссан өдрөөс хойш 2 жил өнгөрсний дараа нас барсанд тооцож болно:

Монгол улсын Иргэний хуульд зааснаар иргэний нас барсанд тооцох шийдвэр гардаг. Энэхүү шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор материаллаг эрх зүйн хувьд өв нээгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийг эрх залгамжлагчаар солих бодит үндэслэл бүрддэг ба хэрэг хянан шийдвэрлэх явцад аль нэг зохигч нас барсан тохиолдолд шүүх нас барсныг тооцох процесс хэрхэн явагддагыг авч үзэцгээе.

### **Зохигчийг нас барсныг тооцох процесс**

*Шүүх нас барсныг тогтоох:*

Иргэн нас барсан нь тодорхой, энэ талаар маргаатай боловч нас барсныг бүртгэлийн байгууллага Иргэний бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн бүртгэх боломжгүй бол иргэний нас барсныг шүүх тогтоодог. Нас барсныг тогтоохдоо хүсэлт гаргагч болон бусад иргэн, хуулийн этгээдээс иргэний нас барсныг нотлох баримтуудыг Иргэний бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.13., 19 дүгээр зүйлд заасан аль байгаа баримтын хамт олж авч үнэлүүлэхээр өгнө.

Шүүхийн шийдвэрийг үндэслэн эрх бүхий байгууллага иргэний нас барсныг бүртгэдэг тул шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Иргэний бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.1<sup>[1]</sup>, 19.5.3<sup>[2]</sup> дахь хэсэгт заасан мэдээллийг баримтаар нотолж, шүүхийн шийдвэрийн “тогтоох” хэсэгт нас барагчийн овог, эцгийн нэр, төрсөн он, сар, өдөр, газар болон нас барагчийн нас барсан он, сар, өдөр, газар мөн иргэний харьяалал, оршин сууж байсан газрыг тодорхой бичнэ. Нас барсныг тогтооход Иргэний шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.14<sup>[3]</sup> дэх хэсгийг баримтална. Шүүхийн шийдвэрт заасан нас барсныг тогтоосон он, сар, өдрийг тухайн иргэний нас барсан өдөр гэж үзнэ<sup>[4]</sup>.

ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.1<sup>[5]</sup>-д заасны дагуу зохигч нас барсан тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрх залгамжлагч тогтоогдох хүртэл заавал түр зогсоох үүрэг хүлээдэг ба шүүх үүнийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг.

Үүнд:

1. ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 1.2<sup>[6]</sup> дахь хэсэгт “Иргэнийг сураггүй алга болсонд болон нас барсанд тооцох хэргийг онцгой ажиллагааны журмаар шүүх шийдвэрлэхээр заасан.”
2. ИХШХШТХ-ийн 137 дугаар зүйлийн 1<sup>[7]</sup> дэх хэсэгт “Иргэний сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлтийг уг иргэний сүүлчийн орчин сууж байсан газрын шүүхэд, хэрэв сүүлчийн оршин сууж байсан газар нь мэдэгдэхгүй бол сүүлчийн ажиллаж байсан газрын харьяалах шүүхэд гаргана.”
3. ИХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “Иргэнийг нас барсанд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрийг уг этгээдийн нас барсан өдөр гэж үзнэ.”

Хэрэг түдгэлзээд онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэн, нас барсан зохигчийн хууль ёсны өвлөгч тогтоогдсоны дараагаар эрх залгамжлах ажиллагаа явагдах талаар доор дэлгэрүүлж авч үзлээ.

## Эрх залгамжлал үүсэх

Зохигч нас барсан эсвэл нас барсанд тооцогдсон тухай албан ёсны баримт болох нас барсны гэрчилгээ, сураггүй алга болсонд тооцогдсон шүүхийн шийдвэр гармагц материаллаг эрх зүйн харилцаанд өв нээгдэх ба өвийг өв залгамжлагч авах хугацаанд шүүх ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.1-д зааснаар хэргийг түдгэлзүүлж болно.

Шинэ эрх залгамжлагч зохигчийн бүх эрх, үүргийг хүлээн авч, хэргийг үргэлжлүүлнэ. Өмнөх зохигчийн үйлдсэн бүх процесс хүчинтэй хэвээр үлдэнэ.

Хэрэв тухайн хэрэг маргаан Иргэний хуулийн 240 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан үүрэг гүйцэтгэгчийн хувийн байдалтай салшгүй холбоотой эрх, үүрэг байвал эрх залгамжлалын журмаар эрх, үүрэг шилжих боломжгүй юм. Онолын ойлголт дээр дурдсанчлан тэтгэлэг тогтоох, нэр төр сэргээх зэрэг хувийн шинжтэй маргааны оролцогч нас барсан тохиолдолд хэргийг эрх залгамжлуулан үргэлжлүүлэх бус ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлийн 117.1 <sup>[2]</sup>дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ. Эсвэл маргааны зүйл эд хөрөнгийн шинжтэй бол Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2<sup>[3]</sup> дахь хэсэгт заагдсаны дагуу олгогдсон “Өвлөх эрхийн гэрчилгээ” нь шүүхэд эрх залгамжлагчаар оролцох гол баримт болно. Шийдвэр гүйцэтгэлийн шатанд талуудын аль нэг нь нас барвал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу эрх залгамжлал хэрэгжүүлнэ. Ийнхүү зохигч нас барсан тохиолдолд эрх залгамжлах ажиллагаа явуулснаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээний уялдаа холбоон дээр үндэслэгдэж, шүүхийн шийдвэрийн тасралтгүй байдлыг хангах ач холбогдолтой.

### 1.1.2 Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сураггүй алга болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэх

**Тодорхойлолт:** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигч иргэн нас барах, эсхүл сураггүй алга болсонд тооцогдох нь материаллаг эрх зүйн харилцаа процессын хувьд өөр этгээдэд шилжих үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг.

Иргэний хуулийн 23 дугаар зүйлийн 23.1<sup>[1]</sup>-д зааснаар иргэн оршин суугаа газраасаа алга болж, нэг жилийн турш сураг чимээгүй болсон тохиолдолд сонирхогч этгээдийн

хүсэлтээр шүүх түүнийг сураггүй алга болсонд тооцдог ба сураггүй алга болсонд тооцох үндэслэлүүдийг дэлгэрүүлж авч үзье.

Шүүх дараах үндэслэлүүдээр сураггүй алга болсонд тооцож болно. Үүнд:

1. ИХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Иргэн оршин суугаа газраасаа сураггүй алга болсноос хойш нэг жилийн хугацаанд түүний байгаа газар нь мэдэгдэхгүй, амьд байгаа эсэх нь тогтоогдохгүй бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх түүнийг сураггүй алга болсонд тооцож болно.”
2. ИХ-ийн 23 дугаар зүйлийн 23.2<sup>[2]</sup> дахь хэсэгт “Сураггүй алга болсон иргэний эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах, хамгаалах зорилгоор шүүх уг хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг томилж болно.” Зохигч сураггүй алга болсон тохиолдолд түүнийг нас барсанд тооцсон шийдвэрт хүчин төгөлдөр болсноор уг этгээдийн хувьд өв нээгдэж, түүний эрх, үүрэг хууль ёсны залгамжлагчдад шилжих эрх зүйн үр дагавар үүсдэг.

Процессын хувьд ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх хэсэгт зааснаар зохигч иргэн нас барсан эсвэл сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түр зогсоодог. Энэхүү түр зогсоосон хугацаанд Нотариатын тухай хуулийн дагуу өвлөх эрхийн гэрчилгээ олгогдох, эсхүл сураггүй алга болсон этгээдийн эд хөрөнгө эрхлэн хамгаалагчийг томилох ажиллагаа хийгдэнэ. Эрх залгамжлал нь зөвхөн нэхэмжлэгч, хариуцагчаар хязгаарлагдахгүй бөгөөд бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэргээс гарахад түүний эрх залгамжлагч нэгэн адил процессын субъект болдог ба зохигч сураггүй алга болсноор эрх залгамжлал хийгдэх холбогдох хуулиудын талаар дурдлаа.

*Хүснэгт 1. 3 Зохигч сураггүй алга болсон тохиолдолд эрх залгамжлах зохицуулалт*

№	Хууль тогтоомж	Зүйл, хэсэг	Зохицуулалт
1	Иргэний хууль, 2002 он	23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг	Оршин суугаа газраасаа алга болсноос хойш хоёр жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй болсон иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх сураггүй алга болсонд тооцож болно.

2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он	80 дугаар зүйлийн 80.1.1 <sup>[1]</sup> дэх хэсэг	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараахь тохиолдолд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ:
3	Иргэний хууль, 2002 он	23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг	“Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн эд хөрөнгөд шүүхээс эрхлэн хамгаалагч тогтоох бөгөөд тухайн этгээдийн асрамжид байсан хүмүүсийн ...”
4	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он	30 дугаар зүйлийн 30.1 <sup>[2]</sup> дэх хэсэг	“Маргаантай эрх зүйн харилцааны зохигчийн аль нэг нь уг эрх зүйн маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон / ... сольж болно.”
5	Шүүгч тогтоол гаргаж, эрх залгамжлагчийг зохигчоор сольж, хэргийг түдгэлзүүлэлтээс гаргана.		

Эх сурвалж: *Legalinfo.mn*

Процессын эрх залгамжлал нь залгамжлагч этгээд өмнөх оролцогчийн хийсэн бүх үйлдэл, эдэлж эрхийг хэрэг зогссон цэгээс нь бүрэн үргэлжлүүлэх боломжийг олгодог. Сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийн хувьд түүний эд хөрөнгийг хамгаалах зорилгоор томилогдсон эрхлэн хамгаалагч шүүх хуралд төлөөлөн оролцох замаар процессын тасралтгүй байдлыг хангадаг.

### 1.1.3 Хуулийн этгээд хянан шийдвэрлэх ажиллагааны татан буугдах тохиолдолд хэрхэн шийдвэрлэх

**Тодорхойлолт:** Компани татан буулгах гэдэг нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож, эрх зүйн чадамжийг нь бүрмөсөн хүчингүй болгох албан ёсны процесс юм. Энэ нь хууль, санхүү, бүртгэлийн олон шат дамжлагатай бөгөөд анхан шатны баримт бичгээс эхлээд улсын бүртгэлээс хасах хүртэл тодорхой журамтай явагддаг.<sup>[1]</sup> Хуулийн этгээд буюу компани хуулийн этгээд татан буугдах талаар Иргэний

хууль болон Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйл болон 26 дугаар зүйл холбогдон ашигладаг ба дараах ойлголтуудыг дэлгэрүүлэн авч үзье.

*Хүснэгт 1. 4 Хуулийн этгээд татан буугдах үеийн хуулийн зохицуулалт*

Татан буугдах үйл явц ба бүрдүүлэх материал:	ИХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1, Компанийн тухай хуулийн 26 <sup>[31]</sup> дугаар зүйлд заасан тодорхойлолт:	Хуудийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 <sup>[32]</sup> дүгээр зүйлд заасан бүрдүүлэх материал:
Үүсгэн байгуулагчдын хурлын тогтоол эсвэл эрх бүхий байгууллагын шийдвэр	Өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан;	баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл; татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/; дуусгалтын тайлан;
Татан буулгах комисс томилж, улсын бүртгэгчид мэдэгдэх.	Дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;	улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; татвар төлөгчийн хасалтын карт; өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр
Татан буугдах тухай мэдэгдлийг олон нийтэд зарлах (хэвлэл мэдээллийн хэрэгслээр)	Үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан	гүйцэтгэх байгууллагын лавлагаа; татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар;
Зээлдүүлэгчдийн шаардлагыг хангах, татвар, нийгмийн даатгалын өрийг барагдуулах.	Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан	хуульд заасан бусад.

Татан комиссын өргөдөл, тайлан баримтыг бүртгэлийн газар хүргүүлэх	буулгах даргын дуусгалтын зэрэг бичиг Улсын ерөнхий улсын бүртгэлд	Хуульд заасан бусад үндэслэл.	
---	--	-------------------------------	--

Эх сурвалж: Legalinfo.mn

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийн этгээд татан буугдсан ч тухайн хэргийг үргэлжлүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг хангах буюу эд хөрөнгөөр хохирсон зохигчийн хөндөгдсөн эрх, ашгийг хамгаалах үүднээс ИХ-ийн 32 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан дарааллын дагуу өр төлбөрөө барагдуулдаг ба үүнд:

**Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана<sup>[33]</sup>:**

- 1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, татварын өрийг хураах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр;
- 2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;
- 3.дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага;
- 4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;
- 5.хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;
- 6.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадад төлөх хөдөлмөрийн хөлс;
- 7.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална. Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно.

Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна. Мөн Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт зааснаар шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

26.2.1. дампуурсан;

26.2.2. нэг ч гишүүн үлдээгүй;

26.2.3. хуульд заасан бусад үндэслэл, Эдгээр үндэслэлүүдийн нэг болох хуулийн этгээд дампуурсан тохиолдолд шүүх хуулийн этгээдийг татан буулгадаг.

Тухайлбал, хуулийн этгээдийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхэд Дампуурлын тухай хуулийн дагуу хэрэг үүсгэж, хэрэг хянан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна гэж Дампуурлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2<sup>[34]</sup> дахь хэсэгт заасан байна.

Дампуурлын тухай хуулиар зохицуулагдаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

1. ИХШХШТХ 155.1<sup>[35]</sup> Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч, эсхүл үүргээ биелүүлж чадахгүй болсон хуулийн этгээд өөрийгөө дампуурсанд тооцуулахаар тухайн хуулийн этгээдийн оршин байгаа газрын шүүхэд хүсэлт гаргана.
2. ИХШХШТХ 155.2<sup>[36]</sup> Хуулийн этгээдийг дампуурсанд тооцох тухай хэргийг хянан шийдвэрлэхдээ уг хэргийн зохигчдод болон тухайн хуулийн этгээд өөрөө хүсэлт гаргасан бол түүний төлөөлөгчид шүүх хуралдаан хэзээ, хаана болох товыг мэдэгдэнэ.

Хуулийн этгээд Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан журмын дагуу татан буугдвал ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлийн 117.1<sup>[37]</sup>, 65.1.10-т заасны дагуу эрх залгамжлагчгүй тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах хууль зүйн зохицуулалттай ба эрх залгамжлагч нь тогтоогдохгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй шийдвэрлэвэл үлдсэн авлагатай хэргийн зохигч нарын эрх ашиг хөндөгдөх эрх зүйн том асуудал гарж ирж байгаа юм. Гэвч эрх залгамжлал нь зөвхөн хэргийн оролцогч солигдох төдий бус, маргаан бүхий эрх зүйн харилцааны тасралтгүй байдлыг хангах замаар Иргэний хуульд заасан иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийн тэгш байдал, өмчийн халдашгүй байдлыг хамгаалахад чиглэгддэг боловч энэхүү байдлыг хангаж чадахгүй байдал практикт тулгамдаж байна.

Эрх залгамжлагч хэрэгт оролцож эхлэхээс өмнө хийгдсэн бүх процессын үйлдэл, цугларсан нотлох баримт нь залгамжлагчид нэгэн адил хүчинтэй байх бөгөөд татан буулгах комисс нь шүүхийн шатанд хянагдаж буй нэхэмжлэлийн шаардлагыг татан буулгах балансдаа тусгаж, хуульд заасан дарааллын дагуу шийдвэрлэх үүрэг хүлээдэг байна. Хэрэв хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болж дампуурлын хэрэг үүссэн бол ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зогсож, Дампуурлын тухай хуулийн тусгай зохицуулалт үйлчлэх ба хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь зөвхөн Улсын бүртгэлийн санд "татан буугдсан" тухай бичилт хийгдсэнээр албан ёсоор дуусгавар болдог. Улсын бүртгэлээс хасагдсан тохиолдолд тухайн этгээд иргэний эрх зүйн харилцааны субъект байхаа больж, шүүх ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болох эрсдэлтэй учир шүүхээс эрх залгамжлагчийг зөв тодорхойлох нь шүүхийн шийдвэр биелэгдэх бодит нөхцөл болон процессын хэм хэмжээг хангах онол, практикийн өндөр ач холбогдолтой гэж дүгнэж байгаа юм.

#### **1.1.4 Шаардлага болон үүргээ зохигч хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шилжүүлэх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх**

**Тодорхойлолт:** Шаардлага гэдэг нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нэг этгээд нөгөө этгээдээсээ хууль болон гэрээний дагуу тодорхой үйлдэл хийх, эсхүл үйлдэл хийхээс татгалзахыг шаардах эрх, эрх зүйн боломжийг хэлнэ.

Үүрэг гэдэг нь И.Кант “Үүрэг гэдэг бол хуулийн хүндэтгэснээр үйлдэх үйлийн зайлшгүй мөн чанар бөгөөд үүрэг нь албадлагаар биш сайн дураар гүйцэтгэх ёстой” буюу хувь хүн бусдын өмнө, нийгмийн болон өөрийнхөө өмнө хүлээсэн хариуцлагыг хэлнэ<sup>[38]</sup>.

Үүрэг нь гэрээний үүрэг болон гэрээний бус хэмээн ангилагддаг. Гэрээний үүрэг ойлголтод талууд байгуулсан гэрээнд заасны биелүүлэх үүрэгийг илэрхийлдэг бол гэрээний бус үүрэгт дараах ойлголтууд багтдаг:

1. Хуульд зааснар үүсэх үүрэг буюу бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх, дундын мөчөөс үүсэх үүрэг, үндэслэлгүйгээр хөрөнгөжснөөр үүсэх үүрэг,
2. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг буюу зөрчлийн улмаас үүсэх үүрэг /деликтийн үүрэг/

*Хүснэгт 1. 5 Зохигч сураггүй алга болсон тохиолдолд эрх залгамжлах зохицуулалт*

<i>Шаардлага шилжих</i>	<i>Үүрэг гүйцэтгүүлэгч</i>	<i>Үүрэг гүйцэтгэгч</i>	<i>Үндсэн үүрэг</i>

	<i>өөрчлөгдөн</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>
<i>Өр шилжих</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>	<i>Өөрчлөгдөнө</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>
<i>Үүрэг солигдох</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>	<i>Хэвээр үлдэнэ</i>	<i>Өөрчлөгдөнө</i>

*Эх сурвалж: Гэрээний эрх зүй I*

Эрх залгамжлах ажиллагаагаар шилжих шаардлага нь шаардах эрх байх ба шилжих үүргийн хувьд гэрээний болон гэрээний бус (хуулиар үүсэх) үүргийн харилцаанд үүсэх боломжтой.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчийн шаардах эрх болон үүрэг шилжих нь материаллаг эрх зүйн хувьд хуулийн этгээд өөрчлөн байгуулагдах (ИХ-ийн 32 дугаар зүйл), иргэн нас барах зэрэг эрх залгамжлалын үндэслэлээр үүсдэг бол; хэргийн оролцогчийн уугуул эрх, үүргийг шилжүүлэхгүйгээр түүний нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх нь Иргэний хуулийн 62 дугаар зүйлд заасан төлөөлөл болон итгэмжлэлийн үндсэн дээр хэрэгждэг. Нэхэмжлэгч тал Иргэний хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасны дагуу шаардах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх тохиолдолд хариуцагчийн зөвшөөрөл шаардлагагүй боловч ИХШхШтХ-ийн 25 дугаар зүйлд заасан зохигчийн эрх, үүргийн хүрээнд шүүхэд энэ тухай нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Харин хариуцагч өөрийн үүргийг бусдад шилжүүлэх тохиолдолд Иргэний хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлийг заавал авснаар процессын эрх залгамжлал хууль ёсны болох үндэслэл бүрддэг. ИХШхШтХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.1-д зааснаар зохигч нас барсан эсхүл хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд шүүх эрх залгамжлагч тодорхой болох хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг заавал түдгэлзүүлэх үүрэг хүлээх бөгөөд эрх залгамжлагч нь өмнөх зохигчийн хийсэн бүх үйлдэл, цуглуулсан нотлох баримтын үр дагаврыг нэгэн адил хүлээн зөвшөөрч хэрэгт оролцдог<sup>[39]</sup>.

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

Эхний бүлэгт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх явцад зохигч сураггүй алга болсон, нас барсан, хуулийн этгээд татан буугдсан болон шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн тохиолдолд хэрэг маргаанаас гарч эрх залгамжлах ажиллагаа явах процесс эхэлдэг бөгөөд үүнд нас барсан, сураггүй алга болсон тохиолдолд нас барсанд тооцсоноор өв залгамжлах ажиллагаа эхлэж, сураггүй алга болсонд тооцогдвол “өвлөх эрхийн гэрчилгээ” болон эд хөрөнгөд эрхлэн хамгаалагч тогтоож, ИХ-ийн 528.1 болон 528.2 дугаар зүйлүүдэд заасны дагуу 3 сарын дотор хамтран амьдарч байсан этгээд өв хүлээн авахаас татгалзаж, бусад өвлөгчид нь 1 жилийн дотор өв хүлээн авах хүсэлт өгөх шаардлагатай байдаг.

Хэрэг маргааны зохигч нь татан буугдаж байгаа хуулийн этгээд бол ИХ-ийн 32 дугаар зүйлд заасан дарааллаар өр төлбөрөө барагдуулдаг ба 32.5 зүйлийн 32.5.1-д “бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, татварын өрийг хураах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр” буюу тэргүүн ээлжинд шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөрийг барагдуулах ёстой гэж заасан байдаг мөн компанийн хөрөнгө өр төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол Компанийн тухай хуулийн 27.3 болон 27.8 заалтын дагуу татан буулгах комисс томилж, компанийн үлдсэн хөрөнгийг худалдаж өр төлбөрийн барагдуулна. Хэрэв компанийн хөрөнгийг худалдсан ч өр төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй, татан буугдаж буй компанийн эрх залгамжлагч томилогдохгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгай зохицуулалт материаллаг болон процессын хуулинд байхгүй тул энэ нь бусад зохигчдын хөндөгдөж болох эрх ашгийн талаар маргаан үүсгэж байгаа юм.

Зохигч ИХ-ийн 67 дугаар зүйлд заасанчлан төөлөгчөөр өөрийгөө төлөөлүүлэж болох ба энэ нь шаардлага болон үүргээ бусдад шилжүүлэх хамгийн хялбар тохиолдол юм. Бусдаар гэрээнд заасны дагуу буюу ИХ-ийн 123.1, 124 дүгээр зүйлд тусгасны дагуу шаардах эрхээ шилжүүлж болно. Энэ тохиолдолд мөн эрх залгамжлах ажиллагаа явуулах ба өмнөх үндэслэлүүдээс хамгийн маргаангүй эрх залгамжлах үндэслэл юм.

Дараагийн бүлгээр эрх залгамжлан авах зохигчдын эрх болон солигдох талаар дэлгэрүүлэн авч үзье

## **1.2 Эрх залгамжлагчийг солих**

**1.2.1 Эрх залгамжлах ажиллагаанд оролцогч эрх зүйн субъектүүд буюу зохигч гэж хэн болох, маргаантай эрх зүйн талаарх ойлголт**

Шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Шүүхээр шийдвэрлэгдэж буй иргэний хэрэг нь иргэд хоорондын, эсхүл иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн эрх, үүргийн маргааныг таслахтай холбоотой байдаг. Энэхүү процессын харилцаанд оролцож буй субъектүүдийг "зохигч" хэмээн тодорхойлох бөгөөд тэдгээрийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлох нь эрх залгамжлах ажиллагааны үндэс болно. Эрх залгамжлах ажиллагаа нь зөвхөн материаллаг эрх зүйн маргаантай харилцаа үүссэн үед л явагдах боломжтой. Маргаантай эрх зүй гэдэг нь шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй талуудын хоорондын эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой тодорхойгүй байдал юм<sup>[40]</sup>.

Хэргийн оролцогч хэргээс гарах буюу солигдох үйл явц нь материаллаг эрх зүйн харилцаан дахь эрх залгамжлал дээр үндэслэгддэг бол тухайн хэргийн оролцогчид болох зохигчид эрх залгамжлах ажиллагаанд оролцож буй субъектүүдийн талаар авч үзье.

### **Эрх залгамжлах ажиллагаанд хамаарах хэргийн зохигчийн бүрэлдэхүүн ба субъектүүд:**

ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар хэргийн зохигчид гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч болон хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож буй бусад этгээдүүд хамаарна. Процессын эрх зүйн харилцаанд оролцож буй “иргэн” гэдэг ойлголт нь зөвхөн Монгол Улсын иргэн төдийгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ч хамардаг.

Мөн хуулийн 26.2-т зааснаар хуулийн этгээд зохигчоор оролцож болох бөгөөд түүнийг төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна. Эрх залгамжлах ажиллагааны хүрээнд зохигч субъектүүдийг дараах байдлаар ангилан тайлбарлаж болно. Эрх залгамжлал нь зөвхөн зохигчийн статус бүхий этгээдэд (нэхэмжлэгч, хариуцагч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд) хамаарч, материаллаг эрх зүйн харилцаанаас үүссэн эрх, үүрэг процессын хүрээнд бүхэлдээ шилждэг.

*Нэхэмжлэгч:* Хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэн, өөрийн болон бусдын нэрийн өмнөөс эрхээ сэргээхээр нэхэмжлэл гаргасан<sup>[41]</sup>.

Эрх залгамжлал үүсэх үед. Жишээ нь, нэхэмжлэгч нас барсан, сураггүй алга болсон эсвэл шаардлагаа бусдад шилжүүлсэн тохиолдолд түүний бүх эрх,

үүрэг бүрэн шилжиж, эрх залгамжлагч нь нэхэмжлэлийг үргэлжлүүлэн дэмжих эсэхээ өөрөө шийдэж, шүүхэд хүсэлт гаргах боломжтой болно.

*Хариуцагч:* Нэхэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлд дурдагдсан этгээдийг хэлнэ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, нотлох баримт гаргах, мэтгэлцэх эрхтэй. Түүний эрх зүйн байдал нь нэхэмжлэгчтэй тэнцүү бөгөөд зохигчийн ерөнхий эрх, үүргийг эдэлнэ<sup>[42]</sup>.

Хариуцагч хэргээс гарах. Нас барах, хуулийн этгээд татан буугдах, үүргээ шилжүүлэх тохиолдолд эрх залгамжлагч нь уг үүрэг, хариуцлагыг хүлээн оролцдог. Жишээ нь, өр төлбөрийн маргаанд хариуцагч нас барвал өв залгамжлагч нь хөрөнгийн хэмжээгээр хариуцна. Гэхдээ хувийн шинж чанартай үүрэг (Иргэний хуулийн 240.1.2, 240.1.3) шилжихгүй.

*Гуравдагч этгээд:* Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гуравдагч этгээдийг 29<sup>[43]</sup> дүгээр зүйлд тодорхойлсон байдаг. Энэ нь шүүхийн санаачилгаар эсвэл шүүхийн шийдвэрээр өөрийн хууль ёсны хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд иргэний хэрэгт оролцож буй этгээдийг хэлнэ. Тэд шүүхийн шийдвэрээр эсвэл өөрийн санаачилгаар оролцож болох бөгөөд нэхэмжлэгч эсвэл хариуцагч эсвэл хоёулангийнх нь эсрэг нэхэмжлэл гаргаж болно.

1. *Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд* (ИХШХШТХ-ийн 29.1): Нэхэмжлэл гаргах, өөрчлөх, татгалзах, эвлэрэх гэх мэт зохиогчийн бүх эрх, үүргийг эдэлнэ. Статус зохиогчтой адил тул эрх залгамжлал бүрэн хамаарна. Нас барсан тохиолдолд эсвэл үүргээ шилжүүлэх үед эрх залгамжлагч нь түүний оронд орж, бие даасан шаардлагаа үргэлжлүүлнэ.
2. *Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд* (ИХШХШТХ-ийн 29.2, 29.3): Зохигчдын маргаантай харилцааны шууд оролцогч биш ч шүүхийн шийдвэр түүний эрх ашигт нөлөөлж болзошгүй тул оролцдог. Энэ тохиолдолд зохигчийн зарим эрх нэхэмжлэлийг өөрчлөх, татгалзах, эвлэрэх эрхийг эдлэхгүй, харин нотлох, тайлбар өгөх, мэтгэлцэх эрхтэй. Эрх залгамжлал хязгаарлагдмал бөгөөд зөвхөн өөрийн ашиг сонирхолтой холбогдсон хэсэгт оролцоно.

Эрх залгамжлал явагдахад гуравдагч этгээдийн статус зохигчийн нэгэн адил хадгалагддаг. Жишээ нь, өв залгамжлалын маргаанд гуравдагч этгээд оролцож байгаа бол түүний эрх залгамжлагч нь шүүхэд хүсэлт гаргаж оролцож болно ба хэргийн оролцогчдын талаар ерөнхийлсөн хүснэгтийг доор авч үзлээ.

*Хүснэгт 1. 6 Хэргийн оролцогчид*

Хэргийн оролцогч		
Гуравдагч этгээд: Зохигчийн хоорондын маргааныг шийдвэрлэх үед эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээд	Зохигч: Нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд	ИХШХШ тухай хуулийн 12.1.2-12.1.4-т заасны дагуу бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа
Нэхэмжлэгч	Бие даасан шаардлага гаргасан 3-дагч этгээд	Прокурор
Хариуцагч	Бие даасан шаардлага гаргаагүй 3-дагч этгээд	Бусад байгууллага
Тэдгээрийн өмгөөлөгч буюу төлөөлөгч		

*Эх сурвалж: Legalinfo.mn*

Эрх залгамжлах ажиллагаа явагдсанаар хөндөгддөг хамгийн том асуудал бол хэргийг түдгэлзүүлснээр бусад зохигчдын буюу хэргийн оролцогчдын эрх ашиг хөндөгдөх асуудал яригддаг тул дэлгэрүүлэн авч үзлээ. Үүнд:

1. Нэхэмжлэгчийн ашиг сонирхол: Нас барсан эсвэл үүргээ шилжүүлсэн нэхэмжлэгчийн эрх залгамжлагч нь нэхэмжлэлийг үргэлжлүүлэн хамгаалж, маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх боломжтой болно.
2. Хариуцагчийн ашиг сонирхол: Хариуцагч нас барсан ч өв залгамжлагч нь хариуцлагыг хүлээж, хэрэг шинээр үүсгэх шаардлагагүйгээр маргааныг шийдвэрлүүлнэ.

3. Гуравдагч этгээдийн ашиг сонирхол: Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн статус хадгалагдаж, түүний эрх ашиг шүүхийн шийдвэрт нөлөөлөх боломж хэвээр үлдэнэ.

Хэдий хэрэг маргаанд оролцож буй зохигчдын эрх ашиг хөндөгдөхгүй байхаар ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлээр хуульчилсан ч өв нээгдэх, өвөөс татгалзах, хуулийн этгээд татан буугдсан ч эрх залгамжлагч олдохгүй, өр барагдахгүй тохиолдолд хэрэг сунжирч, түдгэлзэж бусад зохигчдын эрх ашиг хөндөгдөх асуудал тулгамдсаар байгаа юм.

### **1.2.2 Зохигч, сонирхогч этгээлийн хүсэлтийн дагуу эрх залгамжлагчийг солих талаар**

*Сонирхогч этгээдийн хүсэлтээр эрх залгамжлах:*

Хэрэв хариуцагч нас барсан, сураггүй болсон, хуулийн этгээд татан буугдсан эсвэл үүрэг, өрийг бусдад шилжүүлсэн тохиолдолд нэхэмжлэгч сонирхогч этгээдийн хувиар оролцож, хуучин хариуцагчийг хэрхэн залгамжлах талаар хүсэлт гаргах эрхтэй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.1 дүгээр зүйлд шүүхэд оролцогч этгээд маргаанаас гарсан тохиолдолд сонирхогч этгээдийн хүсэлтээр оролцогчийг залгамжлагчаар солихыг шууд зөвшөөрсөн байдаг.

*Нэхэмжлэгчийн хүсэлтээр эрх залгамжлах:*

Хэрэв хариуцагч нас барсан, сураггүй болсон, хуулийн этгээд татан буугдсан эсвэл үүрэг, өрийг бусдад шилжүүлсэн тохиолдолд нэхэмжлэгч сонирхогч этгээдийн хувиар оролцож, хуучин хариуцагчийг хэрхэн залгамжлах талаар хүсэлт гаргах эрхтэй; тэрээр шүүхэд бичгээр өргөдөл гаргах эрхтэй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.1 дүгээр зүйлд шүүхэд оролцогч этгээд маргаанаас гарсан тохиолдолд сонирхогч этгээдийн хүсэлтээр оролцогчийг залгамжлагчаар солихыг шууд зөвшөөрсөн байдаг. Ийм арга хэмжээ нь нэхэмжлэгчийн эрх ашгийг хамгаалах, процессын шударга бус байдлаас зайлсхийх зорилготой юм. Энэ тохиолдолд Иргэний хуулийн 124 дүгээр зүйлд заасан өр шилжүүлэх журам нь ихээхэн ач холбогдолтой. Хариуцагчийн өр шилжсэнээр тухайн этгээд өрийг шилжүүлсэн эсвэл түүний залгамжлагч хариуцагчийн оронд орж, нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн авах эсвэл маргаанд оролцох ёстой. Энэ тохиолдолд сонирхогч этгээд (нэхэмжлэгч) хуучин хариуцагчийн залгамжлагчийг хэрэгт оруулах хүсэлт гаргах боломжтой бөгөөд шүүх түүнийг оролцогчоор солих шийдвэр гаргаж болно.

### 1.2.3 Эрх залгамжлах ажиллагаан дахь бүх эрхийг эдэлж үүргийг хүлээх талаарх ойлголт

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад хэрэгт оролцож буй зохигч нар эрх, үүргүүдийг хүлээдэг ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад хэргийн зохигч нар ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1<sup>[45]</sup>-д заасан эрх, үүргүүдийг эдлэх ба тухайн маргаанд оролцож буй зохигч нас барсан, сураггүй алга болсон, шаардах эрхээ шилжүүлсэн, хээлийн этгээд татан буугдсан эсвэл нийлсэн тохиолдолд тухайн эрх залгамжилж авсан этгээд зохигчийн эрхийг адил эдлэнэ. Үүнд:

*Хүснэгт 1.7 ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан зохигчийн эрх, үүргүүд*

Зохигчийн эдлэх эрх, үүргүүд	
Зохигчийн эдлэх ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан эрх:	Зохигчийн эдлэх ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан үүрэг:
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох;	<ol style="list-style-type: none"> <li>1. шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;</li> <li>2. шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх;</li> <li>3. шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;</li> <li>4. шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;</li> <li>5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;</li> <li>6. шүүхийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх.</li> </ol>
Гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах болон ИХШХШТХ-ийн 48 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгүүлэх, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;	
ИХШХШТХ-ийн 91 <sup>[46]</sup> дүгээр зүйлд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах;	

Шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих;
Шүүхийн шийдвэрт гомдол гаргах;
Нэхэмжлэлийн бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагатай холбогдуулан хэргийг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах;

Эх сурвалж: *Legalinfo.mn*

Иргэний хуулийн 240.1.2, 240.1.3-т заасан хувийн шинж чанартай үүрэг (хүүхдийн тэтгэлэг төлөх, ёс суртахууны хохирол нөхөн төлүүлэх, зохиогчийн хувийн эрх гэх мэт) эрх залгамжлагчид шилжихгүй, хэрэг дуусгавар болно. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэргээс гарсан тохиолдолд түүний эрх залгамжлагч ч мөн адил процессын субъект болж, бүх эрх, үүргийг эдэлнэ.

#### БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

Энэхүү дэд бүлэгт эрх залгамжлах ажиллагаанд оролцогч субъектүүд болон тэдгээрийн эрх, үүрэг шилжих процесс үндэслэл мөн эрх залгамжлах ажиллагаа хийлгэх хүсэлт гаргаж болох эсэх талаар авч үзлээ. Үргэлжлүүлэн эрх залгамжлах ойлголттой ойролцоо ойлголтууд болох өв залгамжлал болон нэхэмжлэгч, хариуцагч солих гэх түгээмэл практикт ялгагддаггүй ойлголтуудаас зааглан авч үзэх болно.

### **1.3 Эрх залгамжлах ажиллагаатай ойролцоо ойлголтоос ялгах нь**

#### **1.3.1 Эрх залгамжлах ажиллагаа болон өв залгамжлах ажиллагаа буюу ойролцоо ойлголтоос ялгах нь**

*Өв залгамжлах харилцааны талаарх ойлголт*

Өв залгамжлалын эрх зүй нь өөрийн гэсэн өвөрмөц зохицуулалт бүхий иргэний эрх зүйн харилцаа бөгөөд энэ нь иргэний өмчлөх эрх, түүнээс улбаалан гарах бусад эрхийн асуудалтай нягт холбогдсон харилцаа юм. Өв залгамжлал нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч бүхий л этгээдэд хамаарах ойлголт биш харин иргэн хүний хувьд хамаарах хууль зүйн дагуу хийх үйлдэл юм. Энэ нь хууль, тогтоомжид заасан тодорхой нөхцлийг хангасан байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл эрх зүйн харилцаанд оролцогч

өмчлөгч иргэний хувьд өөрийн өмчлөх эрхээ бусдад өв залгамжлуулахдаа хууль ёсоор, эсхүл гэрээслэлээр шилжүүлж болдог.

*Өв залгамжлалын харилцаанд ордог оролцогчид:*

Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд нэг талаас өвлүүлэгч, нөгөө талаас өвлөгч оролцсон урьдаас хүсэл сонирхолоо харилцан илэрхийлэх боломжгүй нэг талт хэлцэл юм. Өөрөөр хэлбэл өв залгамжлах асуудал нь өв шилжихээр хуульд заасан этгээдүүдэд шилждэг болохоос хэн нэг этгээд үүнийг өөрчлөхгүй бөгөөд өөрчлөх хүсэлтэй байгаагаа гэрээслэлээр илэрхийлж болох боловч үүнд өвлөгч этгээд хэрэв хүсэхгүй бол энэ харилцаа нь цаашид үргэлжлэх боломжгүй байдаг. Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд оролцогч өвлүүлэгч гэдэгт иргэний эрх зүйн харилцаанд оролцогч гадаадын болон монгол улсын иргэд хийгээд харьяалалгүй иргэд бүгд хамаарна. Харин өвлөгч гэдэгт нь хуулийн дагуу өвлөх эрхтэй байдаг хууль ёсны өвлөгчид болон гэрээслэлд дурьдагдсан нэр бүхий этгээд хамаарна. Мөн төр энэ харилцаанд өөрийн гэсэн онцлог статустайгаар оролцдог бөгөөд энэ нь хэрэв нас барсан өвлүүлэгчийн өвийг хүлээн авах өвлөгчгүй болон мөн хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгч нь өөрт оногдсон өвөөс татгалзсан зэрэг тохиолдолд төр нь тухайн өвийг өөртөө хүлээн авдаг бөгөөд энэ тохиолдолд төр хүлээж авсан өвийнхөө хэмжээнд түүний бусдад төлөх ёстой байсан өр төлбөр, шаардлага зэргийг хариуцна. Харин өвлөлийн зүйлийн хувьд өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө. Өвлөгдөх эд хөрөнгө гэдэгт үл хөдлөх эд хөрөнгө ба орон сууц, газар, автомашин, хадгаламж гэх мэт хамаарна. Эрх гэдэгт нь компаний эрх, оюуны үнэт зүйл гэх мэт хамаарна. Өвлүүлэгч нь нас барсан өдрөөс, түүнчлэн иргэнийг нас барсан гэж зарласан бол иргэний хуулийн 24 дүгээр зүйлд заасан өдрөөс эхлэн өв нээгдэнэ.

*Өв залгамжлал хэрхэн хийгддэг вэ, ямар шаардлага тулгардаг вэ?*

Өв залгамжлалыг хууль ёсны дагуу болон гэрээслэлийн дагуу хэрэгжүүлдэг. Гэрээслэлээр өв залгамжлах нь өвлүүлэгчийн хүсэл сонирхлыг илүүд үздэг бол хууль ёсоор өв залгамжлах нь хуулийн дагуу түүний эд хөрөнгийг өвлөх ёстой өвлөгчийн хүсэл сонирхолын асуудал яригддаг. Өөрөөр хэлбэл хэрэв өвлөгч нь тухайн эд хөрөнгийг өвлөхийг хүсэхгүй бол, мөн хуулиар тогтоосон хугацаанд өвлөх хүсэлтээ илэрхийлээгүй бол түүнийг сайн дураараа өвөөс татгалзсан гэж үздэг. Энэ ч утгаараа өв залгамжлалын эрх зүйн харилцаа нь 2 тал зэрэг хүсэл сонирхолоо илэрхийлэн хийх хэлцэл биш юм.

**Өв залгамжлах болон эрх залгамжлах ажиллагааны давуу тал болон сул талууд:**

*Өв залгамжлах ажиллагааны давуу тал:* (ИХ-ийн 515–538 дугаар зүйл): Өв залгамжлалын хамгийн том давуу тал нь ИХ-ийн 515.1<sup>[47]</sup>-т зааснаар өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх, үүрэг бүхэлдээ шилждэг тул өвлүүлэгчийн үйл хэргийг цогцоор нь залгамжлах боломж бүрддэг. Мөн ИХ-д зааснаар гэрээслэлээр өвлүүлэгч өөрийн хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байдаг нь иргэний эрх чөлөөг хамгаалах чухал давуу тал болж өгдөг байна.

*Өв залгамжлах ажиллагааны сул тал:* ИХ-ийн 515.2-д зааснаар өвлөгч нь өвлөн авсан хөрөнгийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг заавал хариуцдаг тул өв залгамжлагч санамсаргүй их хэмжээний өр төлбөрийн дарамтанд орох эрсдэлтэй.

*Эрх залгамжлах ажиллагааны давуу тал:* (ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйл): Эрх залгамжлалын гол давуу тал нь процессын тасралтгүй байдлыг хурдасгахад оршино. Мөн ИХ-ийн 32.1-т зааснаар хуулийн этгээд өөрчлөн байгуулагдах, татан буугдах үед эрх залгамжлал нь ажиллагааг тасалдуулахгүйгээр үргэлжлүүлэх боломжийг олгодог.

*Эрх залгамжлах ажиллагааны сул тал:* Нөгөө талаар эрх залгамжлал нь хэд хэдэн хязгаарлалттай. ИХ-д зааснаар үүргийн мөн чанарт харшлах, эсвэл хувь хүнтэй салшгүй холбоотой эрхийг шилжүүлэхийг хориглодог тул зарим тохиолдолд шаардлагатай шилжилт хийх боломжгүй болдог.

Өв залгамжлал нь материаллаг эрх зүйн бүхэлдээ шилжилтийг голлон хангадаг бол эрх залгамжлал нь процессын тогтвортой байдлыг хангахад илүү тохиромжтой. Хоёр ойлголт хоёулаа иргэний эрх зүйн тогтвортой байдал, эрх ашгийн хамгаалалтыг зорьдог ч, хувийн шинж чанартай үүргийн хязгаарлалт, мэдэгдлийн журам, өр төлбөрийн хариуцлагын хэмжээ зэргээрээ практикт өөр өөр эрсдэл үүсгэдэг. Тиймээс шүүхийн практикт эдгээр хоёр механизмыг ялган хэрэглэх, хуулийн зүйл заалтуудыг нарийн уялдуулан тайлбарлах нь маргааныг шуурхай, шударга шийдвэрлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд дараах харьцуулалтыг хүснэгтээр гаргалаа.

### **1.3.2 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх залгамжлах ажиллагааны зарим асуудлыг тухайн хуулийн 28 дугаар зүйлээс ялган тайлбарлах нь**

*Тодорхойлолт:* Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (ИХШХШТХ) 28 дугаар зүйл нь Нэхэмжлэгч уг нэхэмжлэлийг гаргах эрхгүй, эсхүл хариуцагч уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар тогтоогдвол шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр, эсхүл түүний зөвшөөрснөөр нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийг жинхэнэ нэхэмжлэгчээр, хариуцагч биш этгээдийг жинхэнэ хариуцагчаар тус

тус сольж болно. Эдгээр хоёр зүйл заалтыг ялган тайлбарлах нь эрх залгамжлалын онцлог, хэрэгжилтийн хязгаарлалтыг тодорхойлох, практикт гардаг төөрөгдлийг арилгахад чухал ач холбогдолтой ба харьцуулсан хүснэгтийг гаргаж үзэв.

Хүснэгт 1.9 Зохигчийг солих болон Эрх залгамжлах ойлголтын харьцуулалт

Харьцуулах	2 үзүүлэлт 8 дугаар зүйл <sup>[48]</sup> : Зохигчийг солих	30 дугаар зүйл: Эрх залгамжлан авах
Үндсэн шалтгаан	Хамааралгүй этгээдийг нэхэмжлэгч эсвэл хариуцагчаар татсан байх.	Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаанаас гарах.
Ойлголт	Практик болон эрх зүйн алдаа буюу хариуцагчийг буруу тогтоосон.	Нас барах, татан буугдах, шаардах эрх шилжүүлэх
Зөвшөөрөл	Нэхэмжлэгчийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай.	Сонирхогч этгээд эсвэл эрх залгамжлагчийн хүсэлтээр шийдвэрлэнэ.
Хугацаа	Шүүх хуралдаан эхлэхээс өмнө ихэвчлэн шийдэгддэг.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд (давж заалдах, хяналтын шатанд ч) боломжтой.

Эх сурвалж: *Legalinfo.mn*

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

Өв залгамжлах болон эрх залгамжлах харилцаа нь иргэний эрх зүйн субъектүүдийн хооронд эрх, үүрэг шилжих үндсэн ойлголт боловч тэдгээрийн үүсэх үндэслэл, хэрэгжих цар хүрээний хувьд зарчмын ялгаатай байна. Иргэний хуулийн 515 дугаар зүйлд заасан өв залгамжлал нь зөвхөн иргэн нас барснаар үүсдэг нийтийн эрх залгамжлалын онцгой төрөл бөгөөд эд хөрөнгө, эрх, үүрэг нь нэгдмэл байдлаар өвлөгчид шилждэгээрээ онцлогтой. Харин эрх залгамжлал нь иргэн болон хуулийн этгээдийн аль алинд хамаарах илүү өргөн ойлголт бөгөөд Иргэний хуулийн 30 болон 123 дугаар зүйлд зааснаар гэрээний болон хуулийн этгээдийн өөрчлөн байгуулалтын үндсэн дээр эрх, үүргийг хэсэгчлэн буюу тусгайлан шилжүүлэх боломжийг олгодог.

Процессын эрх зүйн хүрээнд ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлд заасан эрх залгамжлал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын аль нэг нь маргаанаас гарахад нас барах, татан буугдах, шаардах эрх шилжих ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилготой. Энэ нь мөн хуулийн 28 дугаар зүйлд заасан

"жинхэнэ бус зохигчийг солих" зохицуулалтаас ялгаатай нь, анхнаасаа зөв талууд маргалдаж байсан боловч объектив нөхцөл байдлын улмаас тал солигдож байгаа явдал юм. Эрх залгамжлагч нь өмнөх оролцогчийн хийсэн бүх процессын үйлдлийг заавал хүлээн зөвшөөрч, хэргийг зогссон цэгээс үргэлжлүүлдэг нь шүүх ажиллагааны хэмнэлттэй, үр нөлөөтэй байх зарчмыг хангадаг.

## **II БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

### **2.2.1 Англо саксон эрх зүйн бүлийн улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх залгамжлах ажиллагааны талаар (АНУ-ын жишээн дээр тайлбарлах нь)**

АНУ нь Холбооны улс тул муж улс бүр өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон хууль тогтоомжийг батлах эрхтэй байдаг. Гэсэн хэдий ч, хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, ард иргэдэд ойлгомжтой болгох үүднээс муж улс болгонд үйлчлэх хууль тогтоомжийг батлан мөрдүүлэх, муж улсууд дотоодын хууль тогтоомжоо батлахдаа загвар болгон ашиглах Холбооны хуулийг батлах боломжтой. Энэ утгаараа Иргэний Процессын тухай Холбооны хууль (Federal Rules of Civil Procedure) нь АНУ-ын бүхий л муж улсад хүчин төгөлдөр үйлчлэх иргэний хэрэг маргааныг зохицуулах гол эх сурвалж болдог.

Тус хуульд эрх залгамжлах ажиллагаанд “Нас барсан” тохиолдол л хамаардаг ба 25 дугаар зүйлд “Зохигчийг солих<sup>[49]</sup>” (Substitution of parties) үндэслэл болон журмын талаар зохицуулсан байна.

25 дугаар зүйл. Зохигчийг солих

а) Нас барах

1) Хэрэв зохигч нас барсан бөгөөд маргааны шаардлага үгүй болоогүй бол, шүүх нас барсан зохигчийг зохих этгээдээр солих захирамжийг гаргаж болно. Зохигчийг солих хүсэлтийг нас барсан зохигчийн эрх залгамжлагч, төлөөлөгч болон хэргийн аль ч тал шүүхэд гаргах боломжтой. Хэрэв нас барсан тухай мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор зохигчийг солих хүсэлтийг гаргаагүй бол, нас барсан этгээдийн шаардлага эсхүл түүний эсрэг гаргасан шаардлагыг хэрэгсэхгүй болгоно.

Түүнчлэн Давж заалдах журмын тухай Холбооны хууль (Federal rules of Appellate Procedure)-д давж заалдах шатанд зохигчийг солих асуудлыг дэлгэрэнгүй байдлаар зохицуулжээ.

43 дугаар зүйл. Зохигчийг солих

а) Зохигч нас барах

1) Давж заалдах гомдол гаргасны дараа. Хэрэв давж заалдах гомдол гаргасны дараа эсхүл давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх үед зохигч нас барсан бол, аль ч зохигч болон зохигчийн төлөөлөгч тухайн зохигчийн төлөөлөгчөөр зохигчийг солих хүсэлтийг шүүхийн нарийн бичгийн даргад гаргаж болно. Хэрэв нас барсан зохигчид төлөөлөгч байхгүй тохиолдолд, давж заалдах шатны шүүх тохиромжтой арга хэмжээг авна.

Дээрх холбооны хууль тогтоомжоос гадна АНУ-ын муж улсууд эрх залгамжлалтай холбоотой дэлгэрэнгүй зохицуулалтуудыг өөрсдийн мужийн хуульдаа тусгаж өгсөн байдаг.

АНУ-ын Флорида муж :

АНУ-ын Флорида мужид хэргийн оролцогч буюу зохигчийн хэн нэг нь нас барсан бол хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбоотой харилцааг тухайн мужийн дотоодын ИПХ-аар зохицуулдаг<sup>[50]</sup>.

Энэ тохиолдолд нас барсан этгээдийн төлөөний эрх залгамжлан авах хүсэлтэй этгээд шүүхэд хүсэлт гаргах үүрэгтэй ба энэ баримт бичгийн зорилго нь нас барсан этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хөрөнгийн эзэн, маргааны зүйлийн өмчлөгч байсан, энэ эрхээ түүнийг төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх олж авч байгаа этгээдэд шилжүүлсэн гэж эрх залгамжлагчийн зүгээс нотлох баримт болох юм.

Хамгийн анхаарууштай нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч тал нас барсан тухай мэдсэнээс хойш 90 хоногийн дотор эрх залгамжлах тухай хүсэлтийг шүүхэд гаргах ёстой байдаг.

Хуульд зааснаар, иргэний хэргийг хянан шийдвэрлэж шүүхээс шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэгч нас барсан тохиолдолд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгохгүй, харин түр түдгэлзүүлдэг байна. Үүний дараагаар эрх залгамжлагчийг тогтоох хугацааг шүүхээс зааж өгөх ба энэ тохиолдолд нас барсан этгээдийн төлөөлөгч буюу эрх залгамжлагч нь нас барсан этгээдийн эд хөрөнгө ба түүний гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хэсгийг төлөөлж шүүхийн процесс ажиллагаанд үргэлжлүүлэн оролцоно.

Эрх залгамжлагчаар нас барсан этгээдийн өв залгамжлагч нарыг тогтоож болох ба нас барсан этгээдийн хөрөнгийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн хувьд түүний өв залгамжлагч нь өвлөх эрхтэй этгээд болох тул түүнийг төлөөлөх боломж бий. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ зохицуулалт нь эрүүгийн эрх зүйгээс иргэний

эрх зүйг ялгах гол түлхүүр болдог. Учир нь эрүүгийн эрх зүйд шүүгдэгч нас барсан тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгодог.

Дээр дурдсан эрх залгамжлагчийг тогтоох хүртэл процесс ажиллагаа буюу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх нөхцөл нь хариуцагч нас барсан тохиолдолд ч хэрэгжинэ.

Иймд хариуцагч хэдийгээр нас барсан ч түүний эд хөрөнгийн эсрэг нэхэмжлэгч талаас нэхэмжлэл гаргах эрхтэй. Нэхэмжлэгч нар нь хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй боловч /punitive damage/ буюу шийтгэлийн шинжтэй нэмэлт нөхөн төлбөр төлүүлэх боломжгүй болдог байна.

АНУ-ын Жоржиа муж :

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нас барсан тохиолдолд “punitive damage” буюу шийтгэлийн шинжтэй нэмэлт нөхөн төлбөрийг төлүүлэх боломж байдаггүй бөгөөд бусад нөхөн төлбөрийг гаргуулах тухай нэхэмжлэгч нар нь нэхэмжлэл гаргах эрхтэй, “хариуцагч нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн, түүнд хохирол учруулсан тул хариуцлага хүлээлгэх нь зүйтэй” боловч энэ нь хариуцагч нас барсны дараа нэлээд бэрхшээлтэй процесс болж хувирдаг байна. Энэ тохиолдолд хариуцагчийн эсрэг бус хариуцагчийн хөрөнгийн эсрэг нэхэмжлэл гаргах нь зүйтэй. Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулах боломж бүрдэнэ<sup>[51]</sup>.

АНУ-ын Иллинойс муж :

Нэхэмжлэл гаргахаас эхлээд хэрэг маргаан үүсгэж хянан шийдвэрлэх нь ихээхэн урт хугацааны үргэлжилсэн процесс ажиллагаа юм. Энэхүү процесст нэхэмжлэгч эсхүл хариуцагч нас барснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохгүй. Шүүхээс нас барсан этгээдийн хувийн төлөөлөгч (итгэмжлэгдсэн төлөөлөгч), нас барсан этгээдийн хөрөнгийг удирдан зарцуулах гүйцэтгэгч гэх мэт этгээдүүдийг томилсноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн үргэлжилнэ.

Тус муж нь The Survival Act гэх баримт бичгээр энэхүү харилцааг дэлгэрүүлэн зохицуулжээ. Энэхүү эрх зүйн эх сурвалжид дурдсанаар нэхэмжлэгчийг нас барахаас өмнө үүссэн болон үүсэх аливаа нэхэмжлэл гаргах шалтгаан болсон үйл явдлыг хэрэгсэхгүй болгохгүй байхад оршино. Энэхүү хуулийг батлагдахаас өмнө “нэхэмжлэгч нас барвал, нэхэмжлэл гаргах үндэслэл дуусгавар болно” гэж үздэг байжээ. The Survival Act-ын зорилго нь хэдийгээр нэхэмжлэгч нас барсан ч түүнд нөхөн төлөгдөх ёстой байсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлж нэхэмжлэлийг шийдвэрлэхэд оршино<sup>[52]</sup>.

## 2.2 Ром-Германы эрх зүйн бүлийн улсуудын эрх залгамжлах ажиллагааны харьцуулсан судалгаа

### 2.2.1 Япон Улс

#### 1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах тухай ерөнхий ойлголт

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авах (訴訟承継) гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх үед, нэхэмжлэлийн зүйлийн (訴訟物) талаарх нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн байр суурь гуравдагч этгээдэд шилжсэн тохиолдолд, тухайн зохигчийн байр суурь ч мөн гуравдагч этгээдэд шилжих явдал юм<sup>[53]</sup>.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авах явдлыг ерөнхий байдлаар Шууд залгамжлал болон Онцгой залгамжлал гэж 2 ангилдаг.

Шууд залгамжлал гэдэг нь зохигч болох хүн нас барах, хуулийн этгээд нэгдэн нийлэх зэрэг эрх залгамжлан авч буй этгээдийн хүсэл зоригоос хамааралгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагдах тохиолдол юм. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

Онцгой залгамжлал гэдэг нь зохигч маргааны зүйлийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдол юм<sup>[54]</sup>. Энэ тохиолдолд, тодорхой процесс ажиллагааны үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагдах ёстой болдог

#### 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах бүтэц

##### 1. Шууд залгамжлал

Япон Улсын ИПХ-д Шууд залгамжлалын тухай зохицуулалт байхгүй боловч, Шууд залгамжлалын үр дагавар болох “хэргийг түр түдгэлзүүлэх зохицуулалт”-ын тусламжтайгаар шууд залгамжлалын үндэслэл болон үр дагаврыг тайлбарладаг.

Эрх залгамжлах хүсэлтийг гаргасан тохиолдолд, шүүхийн зүгээс эсрэг талын зохигчид энэ тухай мэдэгдэнэ (ИПХ 127). Мөн шүүхийн зүгээс хүсэлтийг үндэслэлтэй эсэх (эрх залгамжлах этгээд мөн эсэх)-ийг өөрийн эрх хэмжээгээр шалгаж үндэслэлгүй тохиолдолд хүсэлтийг хэрэгсэхгүй болгоно (ИПХ 128.1). Шүүхийн шийдвэр гарсны дараа дээд шатны шүүхэд бус тухайн шийдвэрийг гаргасан шүүхэд эрх залгамжлах хүсэлтийг гаргаж тухайн шүүх хүсэлтийн үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэнэ (ИПХ 128.2).

Үүнээс гадна, эрх залгамжлах хүсэлтийг гаргах ёстой этгээд нь эрх залгамжлах хүсэлтийг гаргаагүй тохиолдолд, шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг үргэлжлүүлэх

захирамжийг гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах боломжтой (ИПХ 129).

Гэхдээ зохигч нас барсан хэдий ч, зохигчийн нэрийн өмнөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөөлөн явуулах эрх бүхий төлөөлөгч байх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх шаардлагагүй<sup>[55]</sup>.

Хуулийн этгээд нэгдэн нийлснээс бусад хэлбэрээр татан буугдаж буй тохиолдолд, татан буугдах үйл явцын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үргэлжлэх боловч нэгэнт татан буугдсан тохиолдолд хэргийг дуусгавар болгоно<sup>[56]</sup>.

Түүнчлэн, шууд залгамжлалын бүхий л тохиолдлуудад хэргийг түдгэлзүүлнэ гэсэн үг биш бөгөөд зарим тохиолдлуудад хэргийг дуусгавар болгодог. Тухайлбал, зохигч нас барсан тохиолдолд зохигчийн амины эрх өвлөгдөхгүй тул хэргийг дуусгавар болгодог бөгөөд Япон Улсын тогтсон шүүхийн жишиг үүнийг хүлээн зөвшөөрдөг.

## 2. Онцгой залгамжлал

Онцгой залгамжлал гэдэг нь нэхэмжлэлийн зүйл гуравдагч этгээдэд шилжсэн тохиолдол бөгөөд үндсэн хоёр төрөлтэй. Эхнийх нь: Оролцооны залгамжлал буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжилж авч буй этгээд нь хүсэлт гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжлан авах тохиолдол (ИПХ 49) бол удаах нь

Зөвшөөрүүлэх залгамжлал буюу гуравдагч этгээд нэхэмжлэлийн зүйлийг шилжүүлэн авсан тохиолдолд зохигчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг залгамжлуулах тохиолдол юм (ИПХ 50).

Япон Улсын ИПХ-д зааснаар зохигч нас барсан тохиолдолд хэргийг түдгэлзүүлдэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчийн хүсэлтээр эсхүл шүүх өөрийн эрх хэмжээгээр, эрх залгамжлуулах боломжтой. Гэхдээ бүх төрлийн маргааны шаардлага эрх залгамжлагдана гэсэн үг биш бөгөөд эдийн бус амины эрхийн тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа залгамжлагддаггүй онцлогтой.

### 2.2.2 БНСУ

БНСУ-ын ИХШХШтХ нь эх газрын эрх зүйн системд суурилдаг ба 1910 онд Япон Улс нь БНСУ-ыг эзлэн авснаар Япон Улсын Засгийн газрын тогтоолын дагуу тус улсын хууль тогтоомж БНСУ-д үйлчилж, дэлхийн хоёр дугаар дайн дуустал хэрэгжсэн байна.

Түүхээс үзвэл, Япон Улсын ИХШХШтХ нь 1877 онд батлагдсан ХБНГУ-ын ИХШХШтХ-ийг хэсэгчлэн загварчилсан. Европын иргэний эрх зүйн тогтолцоонд суурилсан Япон Улсын ИХШХШтХ-ийг солонгос хэл рүү орчуулж, 1960 онд БНСУ-ын

ИХШХШтХ шинэ хууль батлагдтал Япон Улсын ИХШХШтХ хэрэгжиж эхэлсэн. Иймээс БНСУ-ын ИХШХтХ-ийн зохицуулалт нь Япон Улсын ИХШХтХ-ийн зохицуулалттай нэлээдгүй төстэй байдаг.

### **ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ТАСАЛДАХ**

***233 дугаар зүйл (Хэргийн оролцогч нас барсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)***

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нас барсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түүний хууль ёсоор өв залгамжлагч, эсвэл эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих үүрэгтэй бусад этгээд хариуцна.

(2) Өв залгамжлагч нь бүхий л үйл ажиллагааг шилжүүлэн авахаас татгалзах боломжтой байхад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хариуцуулж болохгүй.

***234 дүгээр зүйл (Хуулийн этгээдийг нэгтгэсний улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)***

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хуулийн этгээд нэгдсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэгдэх замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд, эсхүл нэгдэн нийлсний дараа үлдсэн хуулийн этгээд хариуцна.

***239 дүгээр зүйл (Оролцогч тал дампуурсны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)***

(1) Хуулийн этгээдийг дампуурсан гэж үзвэл дампуурсанд тооцох шийдвэр гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд Өр төлбөрийг нөхөн сэргээх, дампуурлын тухай хуульд заасны дагуу дампуурлын ажиллагаа дуусгавар болсон буюу дампуурсанд тооцогдсон бол төр дампуурсан хуулийн этгээдийн бүхий л үйл ажиллагааг шилжүүлэн авч үргэлжлүүлнэ.

***240 дүгээр зүйл (Дампуурлын үйл ажиллагаа дуусгавар болсонтой холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх)***

(1) Өр төлбөрийг нөхөн сэргээх, дампуурлын тухай хуульд заасны дагуу дампуурах үндэслэлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсний дараа дампуурлын ажиллагаа дуусгавар болох хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

Энэ тохиолдолд дампуурсанд тооцогдсон хуулийн этгээдийн бүхий л үйл ажиллагааг шилжүүлж авсан этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

**244 дүгээр зүйл (Шүүхийн эрх хэмжээгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх)**

(1) Хэрэв талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээн авах хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхийг даалгасан захирамж гаргаж болно.

БНСУ-ын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх залгамжлах нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор “хэргийг түдгэлзүүлэх”, эсхүл “тасалдах арга” хэмжээг шүүхээс авдаг байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасалдсан бол шүүгч өөрийн эрх хэмжээгээр хариуцагч этгээдийг тогтоодог. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг тасалдсан болон түдгэлзсэн бол хариуцагчийг шинээр томилсон үеэс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шинээр эхэлдэг.

**2.2.3 БНХАУ**

Хэргийг хянан хэлэлцэх явцад хэргийн оролцогч (нэхэмжлэгч, хариуцагч) хувь хүн нас барсан тохиолдолд түүний эрх залгамжлагч нас барсан этгээдийн шүүх хуралдаанд оролцох эрхийг өвлөн нэхэмжлэгч, хариуцагчаар хэрэгт оролцож шүүхийн процессыг үргэлжлүүлэх боломжтой<sup>[57]</sup>. Эрх залгамжилж буй этгээдийн сонголтоос хамаарч шүүх хуралдааны эрх залгамжлал үүсэхгүй байх боломжтой<sup>[58]</sup>.

Эрх залгамжлагч нь өв залгамжлалаас татгалзах эрхтэй бөгөөд энэ үед өвлүүлэгчийн бусад этгээдийн өмнө хүлээх үүргийг хариуцах шаардлагагүй юм. Энэ тохиолдолд өвлүүлэгч нь хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчийн алинаар оролцож байснаас үл хамааран эрх залгамжилж буй этгээдэд шүүх хуралдаанд эрх залгамжлахаас татгалзах сонголт нь байдаг. Нөгөө талаас хэрэв эрх залгамжлагч өвийг хүлээж авахаас татгалзаагүй бол өвлүүлэгч этгээд шүүх хуралдаанд хариуцагчаар оролцож үүрэг, хариуцлага хүлээж байсан тохиолдолд өвлөгч нь түүний иргэний процесс дахь байр суурийг заавал орлох ёстой. Харин өвлүүлэгч нь нэхэмжлэгч байсан тохиолдолд өвлөгчид шүүх хуралдаанд эрх залгамжлах эсэхээ сонгох эрх нь чөлөөтэй хэвээр байна.

БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэргийн оролцогч нас барсан үеэс түүний өв залгамжлагч шүүх хуралдаанд эрх залгамжлах эсэхээ илэрхийлэх хүртэл хугацаанд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

шаардлагатай. Хуулийн этгээд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах нь үүнтэй төстэй бөгөөд бас тодорхой ялгаатайгаар явагддаг.

Ерөнхийдөө иргэний процессын явцад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаа хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан тохиолдолд зарчмын хувьд түүний эд хөрөнгийн эрх, үүргийг хүлээн авч буй өөр хуулийн этгээд байгууллага татан буугдсан хуулийн этгээдийн иргэний процессын эрхийг мөн залгамжлан авч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ. Жишээлбэл: хуулийн этгээд хуваагдсан эсхүл нэгдсэн тохиолдолд тухайн нэг буюу хоёр шинэ хуулийн этгээд нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан буугдсан хуулийн этгээдийн эрхийг залгамжлан авч үргэлжлүүлнэ. Хэрэв хэргийн оролцогч хуулийн этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад эрх зүйн чадвар дуусгавар болсон бол тус хуулийн этгээдийг удирддаг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч эсхүл гүйцэтгэх удирдлага нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан оролцоно.

БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлд<sup>[59]</sup> зааснаар дараах нөхцөл байдал үүсвэл хэргийг түдгэлзүүлнэ:

1. Хэргийн оролцогчдын аль нэг нь нас барсан ба эрх залгамжлах этгээдийг хэрэгт оролцох эсэхээ илэрхийлэхийг хүлээх шаардлагатай;

Иргэний хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх явцад ямар нэгэн шалтгаан эсхүл нөхцөл байдлаас болж түр хугацаагаар зогсож байгааг хэрэг түдгэлзэх гэж нэрлэдэг. Түдгэлзүүлсэн хугацаанд тухайн түдгэлзүүлсэн шалтгаан, нөхцөл байдал арилах хүртэл шүүхээс ямар нэгэн ажиллагаа хийгдэхгүй. Дээр дурдсан хэргийг түдгэлзүүлэх шалтгаан арилбал хэргийг үргэлжлүүлнэ.

ИПХ-ийн 150 дугаар зүйлд хэргийг түдгэлзүүлэх 6 үндэслэлийг зааж өгснийг 3 төрөлд хуваан авч үзэж болно.

1. Нэхэмжлэлийн гол зүйл хүлээгдэж байгаа: маргааны аль нэг тал болох иргэн нас барсан бөгөөд эрх залгамжлах этгээд шүүх хуралдаанд оролцох эсэхээ илэрхийлэхийг хүлээх шаардлагатай; маргааны аль нэг тал болох хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан ба түүний эрх, үүргийг залгамжлах этгээд тодорхойгүй байгаа; маргааны аль нэг тал иргэний процессын эрхээ алдсан ба хууль ёсны төлөөлөгч тодорхойгүй байгаа гэх мэт.

2. Форс Мажор: маргааны аль нэг тал давагдашгүй хүчин зүйлийн улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон нөхцөл.

3. Бусад хэргийн оролцоо: Хэргийг шийдвэрлэхэд өөр хэргийг шийдвэрлэсэн шийдвэр ач холбогдолтой бөгөөд хараахан эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа тохиолдол. Хуулийн этгээдийн эрх залгамжлах этгээдийг тодорхойлоход ихээхэн хугацаа зарцуулдаг тул ИПХ-ийн 150 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хэргийг түдгэлзүүлдэг байна. Шүүх хэргийн оролцогчдын хүсэлтийг үндэслэн эсхүл өөрийн санаачилгаар дээрх нөхцөл байдлууд үүссэн бол хэргийг түдгэлзүүлэх захирамж гаргадаг.

БНХАУ-ын ИПХ-ийн тайлбарын 55 дугаар зүйлд зааснаар хэргийн оролцогчдын аль нэг нь нас барсан эрх залгамжлах этгээдийг иргэний хэрэгт оролцох эсэхээ илэрхийлэх шаардлагатай үед шүүхээс хэргийг түдгэлзүүлэх захирамж гарна. Ардын шүүх цаг алдалгүй өвлөгч этгээдэд иргэний хэрэгт тал болон оролцох болон өвлүүлэгчийн эхлүүлсэн иргэний хэрэг нь өвлөгчид хүчинтэй болохыг мэдэгдэнэ<sup>[60]</sup>.

ИПХ-ийн 22 дугаар бүлэгт шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлэх болон дуусгах талаар дараах байдлаар зохицуулсан.

ИПХ-ийн 256 дугаар зүйл. Дараах нөхцөл байдалд Ардын шүүх захирамж гаргаж шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлнэ:

1. Шийдвэрийн гүйцэтгэлийг сунгуулахаар хүсэлт гаргасан;
2. Хэрэгт хамааралгүй этгээд шийдвэр гүйцэтгэлд үндэслэл бүхий татгалзал гаргасан;
3. Хэргийн оролцогчдын аль нэг иргэн нас барсан ба эрх залгамжлах эсхүл үүрэг хариуцах этгээдийг гарч ирэхийг хүлээх шаардлагатай;
4. Хэргийн оролцогчдын аль нэг болох хуулийн этгээд бусад байгууллага үйл ажиллагаагаа зогсоосон, эрх үүрэг хүлээн авч буй этгээд тодорхойгүй<sup>[61]</sup>.

ИПХ-ийн 258 дугаар зүйл. Түдгэлзүүлсэн болон дуусгавар болгосон захирамжийг хэргийн оролцогчид хүргүүлмэгц хүчин төгөлдөр болно<sup>[62]</sup>. ИПХ-ийн тайлбарын 475 дугаар зүйлд зааснаар хэрэв шийдвэр гүйцэтгэх иргэн нас барсан бөгөөд түүний өв залгамжлагч өвийг хүлээж авахаас татгалзаагүй бол Ардын шүүх захирамж гаргаж шийдвэр гүйцэтгэх этгээдийг солих бөгөөд өв залгамжлагч этгээд өвлүүлэгчийн эд хөрөнгийн хэмжээгээр өрийг хариуцна. Хэрэв өвлөгч өвөөс татгалзсан бол Ардын шүүх нас барсан этгээдийн хөрөнгөөс шууд өрийг барагдуулна<sup>[63]</sup>.

БНХАУ-ын ИПХ болон ИПХ-ийн тайлбарт зохицуулснаас үзэхэд зохигчид нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд БНХАУ-ын ИПХ-ийн 150 дугаар зүйлд зааснаар тухайн хэргийг түдгэлзүүлдэг байна. Ийнхүү түдгэлзүүлэх хугацаанд шүүхээс нас барсан этгээдийн өвлөгчид хандан тухайн хэрэгт эрх залгамжлан оролцох эсэхийг тодруулдаг. Хэрэв нэхэмжлэгч нас барсан бол түүний өв залгамжлагч тухайн хэрэгт эрх залгамжлан оролцох эсэх нь өөрийнх нь сонголтын асуудал байдаг бөгөөд хэрэв шүүхэд оролцох эрхээсээ татгалзсан тохиолдолд хэргийг ИПХ-ийн 151 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгоно.

Харин хариуцагч нас барсан тохиолдолд өв залгамжлагч өвийг хүлээн авсан эсэхээс хамааран сонгох эрх нь хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл нас барсан хариуцагчийн өвлөгч өвийг хүлээж аваагүй бол түүнд эрх залгамжлахаасаа татгалзах эрх нь хадгалагдах ба хариуцагчийн өвлөгч өвийг хүлээж авсан бол заавал шүүх хуралдаанд нас барсан хариуцагчийн оронд хариуцагчаар оролцож хэргийг үргэлжлүүлэх бөгөөд энэ тохиолдолд шүүхээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Хуулийн этгээд эсхүл бусад байгууллага татан буугдсан тохиолдолд түүний эд хөрөнгийн эрх үүргийг шилжүүлэн авсан этгээд эрх залгамжлагчаар хэрэгт оролцдог. Давж заалдах болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд мөн адил журам үйлчилдэг байна. Шийдвэр гүйцэтгэлийн үед хариуцагч нас барсан ба өвлөгч өвийг хүлээн аваагүй бол шууд нас барсан хариуцагчийн хөрөнгөөс өрийг барагдуулдаг.

#### БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

Зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсантай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлагдах явдлыг улс орнууд ойлголтын хувьд өөр хоорондоо ялгаатай нэр томъёогоор дотоодын хууль тогтоомждоо зохицуулсан байх боловч хэргийг дуусгавар болгохтой холбоотойгоор үр ашиггүй зардал бий болохоос сэргийлэх, маргааныг эцэслэн шийдвэрлэх, иргэний эрх зүйн субъектийн зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүднээс аль болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгохгүйгээр цаашид үргэлжлүүлэн эрх залгамжлуулах нийтлэг үзэл санааг баримталсан байна. Тодруулбал, АНУ нь нийтлэг эрх зүйн системийг буюу шүүхийн жишгийн эрх зүйг баримталдаг улс хэдий ч АНУ-ын бүх муж улсад нэгэн адил үйлчлэх Холбооны хуулиар дамжуулан “зохигч нас барсан тохиолдолд” тухайн зохигчийг эрх

залгамжлагчаар солих боломж болон арга замыг хуульчилсан, ИПХ-ийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эрх залгамжлагчаар зохих этгээдийг томилох талуудын зүгээс хүсэлт гаргах, зарим муж улсад хүсэлт гаргаагүй бол шүүхээс “зохистой арга хэмжээг авах” буюу эрх залгамжлагчийг өөрийн эрх хэмжээний хүрээнд томилох агуулга бүхий заалт тусгасан талаар дэлгэрэнгүй хуульчилж өгсөн нь судалгаанаас харагдлаа.

Түүнчлэн, эх газрын эрх зүйн системд харьяалагдах улсууд ч нэгэн адил ИПХ-даа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна. Эрх залгамжлал тогтоох нөхцөл байдал үүссэн зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсантай холбоотойгоор судалгааны хүрээнд хамруулсан улсууд зарчмын хувьд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх” үр дагаврыг хуульчилсан байна. Тухайлбал, АНУ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч солих эрх залгамжлах хүсэлт гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг (Холбооны Иргэний процессын хууль 25.а.1). БНХАУ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлах хүсэлт гарах хүртэл хэргийг түдгэлзүүлэх шаардлагатай байдаг (ИПХ 150.1). БНСУ-д ч нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлдэг (ИХШХШтХ 233). Харин Япон Улсад зохигч нас барсантай холбоотойгоор шүүхээс хэргийг түдгэлзүүлдэг хэдий ч (ИПХ 124.1.1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөөлөх эрх бүхий этгээд байгаа тохиолдолд хэргийг түдгэлзүүлэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд явуулдаг онцлогтой байна.

Гэсэн хэдий ч хуулийн этгээд татан буугдах ойлголт, төрөл болон ажиллагаа нь улс орон болгоны хувьд харилцан адилгүй байдаг тул түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үзүүлэх нөлөөний талаар төсөөтэй талыг олж харахад хүндрэлтэй байна. Гэхдээ, Япон Улс, БНСУ болон БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтаас ажиглагдсан нийтлэг тал нь “хуулийн этгээд өөр хуулийн этгээдтэй нэгдэн нийлсэн тохиолдолд шинээр байгуулагдсан хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлан авдаг” явдал юм.

Зарим улсын онцлогоос дурдвал: Япон Улсад хуулийн этгээд татан буугдах ажиллагааны хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үргэлжилдэг хэдий ч нэгэнт татан буугдсан бол хэргийг дуусгавар болгодог. Түүнчлэн, БНХАУ-д хуулийн этгээд татан буугдсан бөгөөд түүний эрх, үүргийг хүлээн авах этгээд тодорхойгүй тохиолдолд, шүүхээс хэргийг түдгэлзүүлдгээс гадна онцлог анхаарал татахуйц нь хуулийн этгээд татан буугдсан хэдий ч хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, хувьцаа

эзэмшигч зэрэг удирдах этгээдүүд эрх залгамжлах боломжтой талаар холбогдох эх сурвалжид дурдсан явдал юм. Дээрх байдлаар хэргийг түдгэлзүүлсний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагддаг нийтлэг тал улс орнуудад ажиглагдах боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах, хэргийг сэргээн явуулах тодорхой ажиллагаа болон журмууд харилцан адилгүй байна. Зохих этгээдийн хүсэлтийг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагдах нь ерөнхий зарчим хэдий ч зарим улс орнууд зохих этгээд хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх, эрх залгамжлуулах боломжийг хуульчилж өгсөн байдаг. Тухайлбал, Япон Улсад зохих этгээдүүд эрх залгамжлах хүсэлтийг гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргах боломжтой (ИПХ 129). БНСУ-д ч мөн адил шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргадаг (ИХШХШТХ 244).

Дээрх байдлаар хэргийг түдгэлзүүлсний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагддаг нийтлэг тал улс орнуудад ажиглагдах боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлах, хэргийг сэргээн явуулах тодорхой ажиллагаа болон журмууд харилцан адилгүй байна. Зохих этгээдийн хүсэлтийг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлагдах нь ерөнхий зарчим хэдий ч зарим улс орнууд зохих этгээд хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх, эрх залгамжлуулах боломжийг хуульчилж өгсөн байдаг. Тухайлбал, Япон Улсад зохих этгээдүүд эрх залгамжлах хүсэлтийг гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргах боломжтой (ИПХ 129). БНСУ-д ч мөн адил шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх захирамжийг гаргадаг (ИХШХШТХ 244). Харин АНУ-ын Холбооны ИПХ-ийн хүрээнд зохих этгээдүүд тодорхой хугацааны дотор хүсэлт гаргаагүй тохиолдолд хэргийг дуусгавар болгохоос өөр аргагүй бөгөөд шүүх өөрийн эрх хэмжээгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, сэргээх боломжгүй (25.а.1). Гэхдээ, давж заалдах шатанд зохигч нас барсан тохиолдолд, шүүх тохиромжтой арга хэмжээг авна гэж шүүхийн эрх хэмжээг хүлээн зөвшөөрсөн (Давж Заалдах журмын холбооны тухай хууль 43.а.1) төдийгүй АНУ-ын муж улсууд хэргийг үргэлжлүүлэх, сэргээх боломжийг илүү уян хатан байдлаар дотоодын хууль тогтоомждоо зохицуулсан байдаг. БНХАУ-ын хувьд зохих этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх залгамжлалаас татгалзах эрхтэй (ИПХ 150.1). Энэ хүрээнд нэхэмжлэгчийн эрх, үүргийг залгамжлах ёстой этгээд хүлээн авахаас татгалзвал хэргийг хэрэгсэхгүй болгодог бол хариуцагчийн тухайд зохих этгээд өвийг хүлээн авсан эсэхээс хамаарч хэргийг хүлээн авах ёстой юу үгүй юу гэдэг нь шийдэгддэг. Мөн, улс орнууд хэргийг түдгэлзүүлэх эсхүл сэргээх хүсэлтийг гаргах хугацааг онцолж

үзсэн байгаа боловч яг тодорхой хугацаа зааж өгсөн нь АНУ байна. Тодруулбал, нас барсан тухай мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дотор зохигчийг солих хүсэлтийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн 20 гаргаагүй бол, шүүх хэргийг хэрэгсэхгүй болгодог (Холбооны Иргэний Процессын хууль 25.а.1).

Дээрхээс үзвэл, улс орнууд зохигч нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим болон үр дагаврыг (хэргийг түдгэлзүүлэх) төсөөтэй байдлаар тодорхой хуульчилж өгсөн байна гэж дүгнэж болно. Харин илүү нарийвчилсан түвшинд буюу ямар төрлийн маргааны шаардлагын эрх, үүрэг залгамжлагдах вэ, хэдий хугацааны дотор хүсэлт гаргах вэ, шүүх өөрийн эрх хэмжээгээр хэргийг сэргээх боломжтой юу, давж заалдах шатанд хэргийг хэрхэх вэ зэрэг асуудлуудын тухайд өөр хоорондоо ялгаатай байдлаар гадаадын орны эрх зүйн зохицуулалтад тусгасан байдал ажиглагдлаа. Эдгээр нарийн асуудлуудын хувьд шүүхийн эрх хэмжээг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн гэж үзэх боломжтой байна. Түүнчлэн шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад эрх залгамжлах явдалтай холбоотой нэлээдгүй олон нөхцөл байдлыг харгалзаж үзэх шаардлага тулгардаг тул хэргийг шууд шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдал үүсдэг.

### **III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

*Ориил:* Эрх залгамжлах ажиллагаан дахь маргаантай эрх зүйн харилцааг зохицуулах онолын үндэслэлүүдийг өмнөх бүлэгт судалсан бол энэ бүлэгт тухайн хууль эрх зүйн зохицуулалтын практик хэрэгжилтийг шүүхийн шийдвэрүүдийн дүн шинжилгээгээр харуулах зорилготой. Шүүхийн практик нь хууль тогтоомжийн бодит хэрэглээ, түүний давуу тал болон дутагдлыг илрүүлэх, онолын дүгнэлтүүдийг батлах эсвэл засаж сайжруулах чухал эх сурвалж юм.

Шүүхийн 2025 онд шийдвэрлэгдсэн 2024 оны жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайланд анхан шатны шүүх дэх оны хэргийн үлдэгдэлийг авч үзэхэд 1919 хэрэг буюу 13.3 хувь, хойшлуулсан хэргийн тоо 547 хэрэг буюу 41.5 хувиар өсжээ. 2024 оны байдлаар түдгэлзүүлсэн хэрэг 1592, хугацаа хэтэрсэн хэрэг 2963 байгаа явдал нь шүүхийн практикд хугацаа хэтэрж, сунжирдаг үүнээс болж бусад зохигчдын эрх ашиг

хөндөгдсөөр байгаагын илрэл болж байгаа бөгөөд хэргийг ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн дагуу хойшлуулах, түдгэлзүүлэх ажилагаа голчилон хийгддэг эрх залгамжлах ажиллагаа ч мөн энэхүү хэрэг удаашрах шалтгаанд багтдаг гэдэг үүднээс үзүүлэлтийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2.1 *Анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэл /2024/*

№	Үзүүлэлт	2024 он	Хувь хэмжээ
Тайлан дахь эцсийн үлдэгдэл		16344	100%
1	Хуулийн хугацаанд	9923	60.7%
2	Хойшлуулсан	1866	11.4%
3	Түдгэлзүүлсэн	1592	9.9%
4	Хугацаа хэтэрсэн	2963	18.2%

*Эх сурвалж: Шүүхийн тайлан 2025*

**Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал:** Шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 32465 хэргийн 7654 хэрэг буюу 23.6 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон, 8412 хэрэг буюу 25.9 хувийг нь ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн бол 16399 хэрэг буюу 50.5 хувийг ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ.

График 1. *Иргэний хэрэг, маргааны хянан шийдвэрлэгдсэн байдал*

*Эх сурвалж: Монгол Улсын шүүхийн 2026 оны 1 дүгээр улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ*

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэргийн тоо 2523 хэрэг буюу 42.8 хувиар, ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 4367 хэргээр буюу 2.3 дахин өссөн байна. Энэ хүртэл бид 2024-2026 оны хоорондох иргэний хэрэг, маргаан хянан шийдвэрлэгдсэн байдал болон анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэлийн талаарх авч үзсэн ба үүнээс түдгэлзүүлсэн хэрэг 1592, хугацаа хэтэрсэн хэрэг 2963, Шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 32465 хэргийн 7654 хэрэг буюу 23.6 хувийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон байгаагаас авч үзэхэд шүүхийн практикт

хэрэг түдгэлздэг, хойшилдог, хэрэгсэхгүй болж зохигчдын эрх ашиг хөндөгддөг болох нь илэрсээр байна.

Доорх хэсэгт эрх залгамжлах шүүхийн шийдвэрийг судалж, дүн шинжилгээ хийлээ.

### 3.1 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Судалгаанд 2015–2024 оны хооронд Улсын дээд шүүх, аймаг, дүүргийн шүүхүүдээс шийдвэрлэгдсэн 5 шүүхийн шийдвэр: Үүнээс 1 хэрэг нь Дээд шүүхийн (001/ХТ2025/00008), 4 хэрэг нь анхан болон давж заалдах шатны шүүхэд) хамрагдсан. Эдгээр шийдвэрүүдийг сонгон авсан үндэслэл нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасан хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн зэрэг нөхцөлтэй шууд холбоотой байсан.

Эдгээр шийдвэрүүдийг маргааны төрөл (иргэний, захиргааны), шүүхийн шат, шийдвэрлэсэн байдал, эрх залгамжлалын практик бэрхшээл зэргээр ангилан тоон чанарын дүн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнг доорх хүснэгтэд нэгтгэв.

Энэхүү дүн шинжилгээний зорилго нь:

1. Онолын судалгаанд дүгнэгдсэн эрх зүйн зохицуулалтын бодит хэрэгжилтийг тодорхойлох;
2. Шүүхийн практикт гарч буй нийтлэг асуудал, зөрчил, сайн туршлагыг илрүүлэх;
3. Эрх залгамжлах ажиллагааны үр нөлөөг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад туслах явдал юм.

Хүснэгт 3.1 Дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэрүүд

№	Шүүхийн харьяалал	Шийдвэрийн дугаар	Маргааны төрөл	Шийдвэр
1		001/ХТ2025/00008	Зээлийн гэрээ	Хариуцагч Д.З-н эрх залгамжлагчаар түүний эхнэр Д.П тогтоогдсон бөгөөд Д.П нь гагцхүү процессын эрх, үүргийг өөртөө шилжүүлэн авсан эрх залгамжлагч болно. Харин эрх залгамжлал нь материаллаг эрх зүйн харилцаанд

				үйлчлэхгүй учраас Д.П нь зээлийн үүргийг өөрийн эд хөрөнгөөр хариуцах үндэслэлгүй юм. Эрх залгамжлагчийн хариуцлага нь хариуцагч Д.З-н хүлээсэн үүргийн хэмжээнд, зээлийн болон барьцааны гэрээгээр хязгаарлагдах учиртайг дурдах нь зүйтэй гэж үзсэн.
2		129/ШШ2022/00702	Санхүүгийн түрээс /лизинг/	Эрх шилжсэн, эрх залгамжлан авсан үйл баримт нь хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн хүндэтгэн үзэх шалтгаан биш тул хөөн хэлэлцэх хугацааг сэргээх үндэслэл болохгүй.
3	Иргэний шүүх /анхан, давах, хяналтын шатны шүүх/	210/МА2023/01085	Ажил гүйцэтгэх	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт зааснаар эрх залгамжлагч Г.А- нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Зохигчдын хооронд үүссэн маргаан нь Орон сууц захиалгаар бариулах тухай гэрээ-тэй холбоотой маргаан буюу өвийн маргаан биш байх тул ...Г.А- нь хууль ёсны өвлөгч эсэхийг шүүх тогтоогоогүй байж хэргийг шийдвэрлэсэн... гэх хариуцагч талын давж заалдах гомдол үндэслэлгүй.
4		210/МА2024/01601	Зээлийн гэрээний үүрэг	Хариуцагч Д.З-н эрх залгамжлагчаар түүний эхнэр Д.П тогтоогдсон бөгөөд Д.П нь гагцхүү процессын эрх, үүргийг өөртөө шилжүүлэн авсан эрх залгамжлагч болно. Харин эрх залгамжлал нь материаллаг эрх зүйн харилцаанд үйлчлэхгүй учраас Д.П нь зээлийн

			үүргийг өөрийн эд хөрөнгөөр хариуцах үндэслэлгүй юм. Эрх залгамжлагчийн хариуцлага нь хариуцагч Д.З-н хүлээсэн үүргийн хэмжээнд, зээлийн болон барьцааны гэрээгээр хязгаарлагдах учиртайг дурдах нь зүйтэй гэж үзэв.	
5	Захиргааны /анхан, давах шатны шүүх /	221/МА2015/0204	Бусад	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлагч оролцсоноор л эрх үүрэг нь эрх залгамжлагчид шилжих ба харин энэ журамд заасны дагуу эрх залгамжлагч оролцоогүй тохиолдолд эрх үүрэг нь эрх залгамжлагчид шилжихгүй юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэгч тал хүсэлт гаргаагүй байхад анхан, давж заалдах, хяналтын аль ч шатны шүүхээс сайн дураараа эрх залгамжлагчийг томилох, тогтоох, эрх залгамжлагчаар аль нэг байгууллагыг оролцуулах ажиллагааг хийх боломжгүй байна.
6		221/МА2018/0563	Газар	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс түүний эрхийг залгамжлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэх боловч эрх залгамжлах асуудал нь хэргийн оролцогч болсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нас барсан буюу сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд түүний эрхийг залгамжлан оролцуулахаас бус шүүхэд

			<p>нэхэмжлэл гаргахаас өмнө нас барсан иргэнийг төлөөлж, улмаар эрхийг залгамжлуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан нь хуулийн дээрх заалттай нийцээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна</p>
--	--	--	---

*Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан*

Дүгнэлт:

Эдгээр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрүүдийн эрх залгамжлах голчилох шалтгаан нь зохигч хэргээс гарсан буюу нас барсан тохиолдол байгаа бөгөөд шүүх хуулийг хэрэглэхдээ ИХШХШТх-ийн 30.1, 117 эдгээр заалтуудыг хавсаран хэрэглэж байна. Үүнд эрх залгамжлах ажиллагаатай холбоотой хөөн хэлэлцэх хугацаа, нэхэмжлэл гаргахаас өмнө нас барсан иргэнийг төлөөлөх, эрх залгамжлагчийн хариуцлага нь хариуцагчийн хүлээсэн үүргийн хэмжээнд, тусгайлсан гэрээгээр хязгаарлагдах зэрэг нарийн хуулиар тусгагдаагүй ойлголтууд илэрж шүүх болон зохигчдын хооронд үл ойлголцол дагуулж байна.

Мөн иргэний хэргийн анхан шатны шүүхийн захирамжаар Нэхэмжлэгч "А" компаниас хариуцагч "Б" компанид холбогдуулан гаргасан 150 сая төгрөг гаргуулах тухай хэргийг хянан шийдвэрлэх явцад хариуцагч "Б" компани нь Улсын бүртгэлийн газарт татан буугдсан бүртгэл хийлгэсэн шүүхийн шийдвэр байна. Шүүх "хариуцагч хуулийн этгээд утсан, эрх залгамжлагч байхгүй" гэж дүгнэн ИХШХШТХ-ийн 117.1.2-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Энэ нь шүүхийн практикт хариуцагч хуулийн этгээд шүүхэд хэрэг хянагдах явцад татан буугдсан тохиолдолд шүүхүүд ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлийг хэрэглэж, татан буулгах комисс эсвэл үүсгэн байгуулагчийг процессын эрх залгамжлагчаар татахын оронд, ИХШХШТХ-ийн 117.1.2-т заасан "хариуцагч хуулийн этгээд татан буугдсан" гэх үндэслэлээр хэргийг шууд хэрэгсэхгүй болгох практик давамгайлж байна. Энэ нь нэхэмжлэгчийн шүүхээр эрхээ хамгаалуулах үндсэн эрхийг зөрчиж, хариуцагч тал шүүхийн шийдвэр, өр төлбөрөөс зугтах зорилгоор компани зориуд татан буулгах хуулийн цоорхойг үүсгэж байна.

### **3.2 Эрх залгамжлалын зохицуулалтын хэрэгжилтийн судалгаа: Асуумжийн судалгааны үр дүн**

*Оришил:* Энэхүү хэсэгт эрх залгамжлалтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг практикт хэрэглэхэд тулгарч буй асуудлуудыг бодит түвшинд тодорхойлох зорилгоор шүүхийн тамгын газрын мэргэшсэн албан хаагчид болох шүүгчийн туслахуудын дунд явуулсан асуумжийн судалгааны үр дүнг нэгтгэн шинжлэв.

#### 2.4.1. Судалгааны арга зүй ба зорилго

Судалгааг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн Иргэний хэргийн анхан шатны -ийн нийт [9] шүүгчийн туслах, Нийслэлийн Иргэнийхэргийн хялбаржуулсан шатны шүүхийн [4] шүүгчийн туслахуудыг хамруулан асуумжийн аргаар судалгаа авсан.

**Зорилго:** Эрх залгамжлалтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгарч буй хүндрэл, хууль хэрэглээний тодорхойгүй байдлыг практикт түвшинд тодорхойлох.

#### 2.4.2 Судалгааны үр дүн

1. Эрх залгамжлах үед (нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд) ямар практикт бэрхшээл хамгийн их тохиолддог вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.1 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Эрх залгамжлах үед хамгийн их тохиолддог практикт бэрхшээл нь А сонголт болох өв залгамжлагч, эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл (64.2%) байгаа нь тодорхой байна.

2. Эрх залгамжлалын механизм хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

*График 1.2 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Үлдсэн сонголтууд (маш бага, бага, сайн, маш сайн) тус бүр ердөө 1%-ийг эзэлж байгаа нь судалгаанд оролцогчдын дийлэнх нь эрх залгамжлалын механизмыг шүүхийн ажиллагааны хурдыг “муу ч биш, сайн ч биш” түвшинд нөлөөлдөг гэж үзэж байгааг илтгэж байна.

3. Эрх залгамжлалтай холбоотой хамгийн их тулгардаг практик бэрхшээл юу вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.3 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Эрх залгамжлалтай холбоотой хамгийн их тулгардаг практик бэрхшээл нь А сонголт буюу эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл (50%) байна. В (хэргийг түдгэлзүүлэх хугацаа уртсах – 24.1%) болон С (материаллаг ба процессын эрх зүйн ялгааг ойлгохгүй байх – 24.1%) сонголтууд тэнцүү хувь эзэлж байгаа нь хоёр асуудал нэг нь нөгөөгөө шууд үүсгэдэг болохыг харуулах боломжтой байна.

4. Доорх 4 нөхцлийн аль нэгэнд (эсвэл хэд хэдэнд) эрх залгамжлал хийх үед хамгийн их бэрхшээл тулгардаг вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.4 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Эрх залгамжлал хийх үед хамгийн их бэрхшээл тулгардаг нөхцөл нь В сонголт: сураггүй алга болсонд тооцогдсон (50%) байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь А (28.6%), D (28.6%), С (21.4%) сонголтуудаас хамаагүй өндөр байна. Иргэний хуулийн 23 дугаар зүйлд зааснаар сураггүй алга болсонд тооцогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр тогтоодог бөгөөд нас барсан тохиолдолоос ялгаатайгаар нэмэлт шүүхийн ажиллагаа,

удаан хугацааны нотлох баримт цуглуулах (алга болсон огноо, 2 жилийн хугацаа, гэрчүүдийн мэдүүлэг, эрэл суралгийн материал гэх мэт) шаарддаг. Иймээс өв залгамжлагч, эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл болох 1-р асуулт, 3-р асуулт тай шууд холбогдож, хэргийг түдгэлзүүлэх хугацаа уртсах нөхцөлийг бий болгож байна.

5. Эрх залгамжлалын механизм хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал-д хэрхэн нөлөөлдөг вэ?

*График 1.5 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Эрх залгамжлах ажиллагаа нь шүүхийн ажиллагааг бүрэн саатуулахгүй ч, тодорхой хэмжээгээр удаашруулдаг төвийг сахисан сөрөг шинжтэйг харуулж байна. Үүнийг 1-р асуулт, 3-р асуултад тодорхойлогдсон өв залгамжлагч, эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл болон 4-р асуултын 50%-д тодорхойлогдсон сураггүй алга болсон этгээдийн статус тогтоох асуудлууд нь энэхүү сөрөг үнэлгээний гол шалтгаан болж байна.

6. Эрх залгамжлах ажиллагаа (ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйл)-ыг илүү үр дүнтэй, шуурхай, иргэдийн эрх ашгийг илүү сайн хамгаалахад тохиромжтой болгохын тулд та ямар санал, зөвлөмж өгөх вэ?

*Хүснэгт 3.3 Судалгааны үр дүн*

Асуултын хариултауд:
Иргэдэд энэ талаар мэдээлэл танилцуулах
Одоогоор байхгүй
Байхгүй
Хувийн байдлыг таниулах

Дүгнэлт: Иргэдэд эрх залгамжлалын механизм, шаардлагатай баримт бичиг, сураггүй алга болсон этгээдийн статус тогтоох журам, материаллаг ба процессын эрх зүйн ялгаа

зэрэг мэдээллийг тодорхой, хүртээмжтэй байдлаар өгөхгүй байгаа нь практикт гол бэрхшээл үүсгэж, шүүхийн ажиллагааг удаашруулж байна.

7. Зохигч иргэн нас барсан тохиолдолд эрх залгамжлал хийхэд хамгийн их тулгардаг практик бэрхшээл юу вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.6 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Зохигч иргэн нас барсан тохиолдолд эрх залгамжлал хийхэд хамгийн их тулгардаг практик бэрхшээл нь А сонголт: өв залгамжлалын гэрчилгээ авах, өв залгамжлагчдыг тодорхойлох хүндрэл (50%) байна. Хоёрдугаарт В сонголт (28.6%) : үүрэг хувийн шинж чанартай эсэхийг тодорхойлох асуудал эзэлж байна.

8. Зохигч сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд эрх залгамжлал хийхэд хамгийн их саад болдог зүйл юу вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.7 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Зохигч сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд эрх залгамжлал хийхэд хамгийн их саад болдог зүйл нь эрх залгамжлагч (асран хамгаалагч эсвэл төлөөлөгч)-ийг тодорхойлох хүндрэл (50%) байна.

9. Хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх явцад татан буугдсан тохиолдолд хамгийн их тулгардаг бэрхшээл юу вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.8 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх явцад татан буугдсан тохиолдолд хамгийн их тулгардаг бэрхшээл нь татан буулгах комисс, эрх зүйн байдлыг тодорхойлох (50%) байна.

10. Зохигч шаардлага эсвэл үүргээ бусдад шилжүүлсэн тохиолдолд эрх залгамжлал хийхэд хамгийн их анхаарах зүйл юу вэ? (нэгээс илүү сонгох боломжтой)

*График 1.9 Судалгааны үр дүн*

Дүгнэлт: Практикт энэ гэрээний хүчинтэй байдлыг шалгахгүйгээр эрх залгамжлагчийг хэрэгт шууд татах оролдлого гаргаж, дараа нь давж заалдах шатанд шийдвэр хүчингүй болох эрсдэл үүсгэж байна. В ба С сонголтууд тэнцүү (21.4%) байгаа нь шилжүүлсэн этгээдийн хэрэгт оролцох хүсэлт, материаллаг эрх зүйн харилцаа бүрэн шилжсэн эсэхийг шалгах асуудал чухал боловч гэрээний хүчинтэй байдал шалгагдаагүй тохиолдолд эдгээр нь утгагүй болдгийг харуулж байна.

#### **Асуумжийн судалгааны дүгнэлт:**

Судалгааны үр дүнгээс харахад эрх залгамжлалтай холбоотой хамгийн их тохиолддог практик бэрхшээл нь өв залгамжлагч, эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл байна. Сураггүй алга болсонд тооцогдсон (50%) болон хуулийн этгээд татан буугдсан (татан буулгах комиссын статус тодорхойлох 50%) тохиолдолд эрх залгамжлагч (асран хамгаалагч, төлөөлөгч)-ийг тодорхойлох ажиллагаа хамгийн их хүндрэлтэй байгаа нь ИХШХШТХ 30.1-ийн практик хэрэгжилтийг удаашруулж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Эрх залгамжлах ажиллагааны процесс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдалд “төвийг сахисан болон сөрөг” нөлөө үзүүлж байгаа нь материаллаг ба процессын эрх зүйн ялгааг ойлгохгүй байх (24.1%–28.6%), хэргийг түдгэлзүүлэх хугацаа уртсах (24.1%) зэрэг харилцан холбоотой асуудлуудаас үүдэлтэй юм.

Зохигч шаардлаг болон үүргээ бусдад шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэх гэрээний хүчинтэй байдлыг шалгах (42.3%) асуудал голлон харагдаж байна. Иргэдэд эрх залгамжлал, шаардлагатай баримт бичиг, материаллаг эрх зүй -процессын эрх зүй ялгаа зэрэг мэдээллийг хүртээмжтэй өгөхгүй байгаа нь практикт гол бэрхшээл болж, шүүхийн ажиллагааг удаашруулж байгааг судалгаанд оролцогчдын саналыг баталж байна.

Товчхондоо, эрх залгамжлал нь хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд маш бага зохицуулалттай, тусгайлан нөхцөлүүд дээр хэргийн зохигчдын эрх ашгийг хамгаалах шүүхийн оролцоог хангалттай тусгаж өгөөгүйгээс материаллаг эрх зүйн зохицуулалт дутмаг болж үүсэж байна. Үүнээс шүүхийн шуурхай байдал, иргэдийн эрх ашгийг хамгаалахад сөргөөр нөлөөлж байгааг судалгаа тодорхой харууллаа.

- [1] Etymonline, “Origin and history of right”, *American Political Science Review* 101, no1, 2010
- [2] Монгол улсын Үндсэн хууль, 1992, 16 дугаар зүйл
- [3] Etymonline, “Origin and history of right”, *American Political Science Review* 101, no1, 2010
- [4] William Smith John Murray, ”D.C.L., LL.D.: A Dictionary of Greek and Roman Antiquities”, no11,( September 1875), getarchive.com
- [5] Их Засаг Олон Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, *ИХШХШ эрх зүйн хэрэглээ, дадлага*, Улаанбаатар хот., 2004 он, 65 дахь тал
- [6] Их Засаг Олон Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, *ИХШХШ эрх зүйн хэрэглээ, дадлага*, Улаанбаатар хот., 2004 он, 65 дахь тал
- [7] Иргэний хууль, 2002, 24 дүгээр зүйл
- [8] Иргэний хууль, 2002, 23 дугаар зүйл
- [9] Иргэний хууль, 2002, 32 дугаар зүйл
- [10] Иргэний хууль, 2002, 123 болон 124 дүгээр зүйл
- [11] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх тухай хууль, 2002, 240 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг
- [12] ИХШХШТХ, 2002, 240 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг

- [13] Улсын дээд шүүх, *ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар*, Улаанбаатар хот., 2008 он, 45 дахь тал
- [14] Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 1999, 38 дугаар зүйл
- [15] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх тухай хууль, 2002, 65 дүгээр зүйлийн 1.10 дахь хэсэг
- [16] ИХ, 2002, 24 дүгээр зүйл
- [17] Иргэний бүртгэлийн тухай хууль, 2018, 19 дүгээр зүйл 5.1 дэх хэсэг
- [18] Иргэний бүртгэлийн тухай хууль, 2018, 19 дүгээр зүйл 5.3 дэх хэсэг
- [19] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх тухай хууль, 2002, 135 дугаар зүйлийн 2.14 дахь хэсэг
- [20] Монгол улсын дээд шүүх, *“Онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” /Зөвлөмж/*, Улаанбаатар хот, 2012 он
- [21] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [22] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 133 дугаар зүйлийн 2 дэх хэсэг
- [23] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 137 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [24] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [25] Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2011, 43 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг
- [26] ИХ, 2002, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [27] ИХ, 2002, 23 дугаар зүйлийн 2 дэх хэсэг
- [28] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх хэсэг
- [29] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг
- [30] Алисон ба Кайт хуулийн фирм, Компани хэрхэн татан буугдах вэ?, 2025
- [31] Компанийн тухай хууль, 2010, 26 дугаар зүйл

- [32] Компанийн тухай хууль, 2010, 26 дугаар зүйл
- [33] Иргэний хууль, 2002, 32 дугаар зүйлийн 5 дахь хэсэг
- [34] Дампуурлын тухай хууль, 1997, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг
- [35] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 155 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [36] ИХШХШТХ, 2002, 155 дугаар зүйлийн 2 дэх хэсэг
- [37] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 117 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг
- [38] Э.Нандин-Эрдэнэ, Үүрэг ба хариуцлага, 2021
- [39] Монгол Өмгөөлөл Хууль Зүйн Фирм, “Шаардах эрхээ шилжүүлэр, өр шилжих зохицуулалтын хэрэгцээ, прогресс /ИХ 123, 124/ ”/Өгүүллэг/ Улаанбаатар хот, 2016 он
- [40] Улсын дээд шүүх, ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар хот., 2008 он, 46 дахь тал
- [41] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 27 дугаар зүйл
- [42] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
- [43] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 29 дүгээр зүйл
- [44] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2017, 60 дахь тал
- [45] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
- [46] ИХШХШТХ, 2002, 91 дүгээр зүйл
- [47] Иргэний хууль, 2002, 515 дугаар зүйлийн 1 пэх хэсэг
- [48] Иргэний хууль, 2002, 28 дугаар зүйл
- [49] Federal Rules of Civil Procedure, (1938), Act §25, Substitution of parties
- [50] what happens if someone dies before settlement in a civil lawsuit”<https://jflawfirm.com/what-happens-if-someone-dies-before-settlement-in-a-civil-lawsuit/> (Сүүлд үзсэн: 2026.04.03).

[51] thejusticelawyer, “what-if-the-defendant-dies-in-litigation” <https://www.thejusticelawyer.com/blog/what-if-the-defendant-dies-in-litigation/> (Сүүлд үзсэн: 2026.04.04).

[52] oflaherty law “-if one of the parties dies” <https://www.oflaherty-law.com/learn-about-law/is-a-lawsuit-in-illinois-terminated-if-one-of-the-partiesdies> (Сүүлд үзсэн: 2026.04.04).

[53] 渡部美由紀他, 『民事訴訟法』, 日本評論社, 2016. (Watanabe Miyuki hoka, Minji Soshō Hō, Nihon Hyōronsha, 2016).

[54] 高橋宏志, 『重点講義民事訴訟法（上）』, 有斐閣, 第2版補訂版, 2013. (Takahashi Hiroshi, Jūten Kōgi Minji Soshō Hō (Jō), Yūhikaku, Dai 2-han hoteiban, 2013).

[55] 伊藤眞, 『民事訴訟法』, (東京: 有斐閣, 第6版, 2018), 262頁参照. (Itō Makoto, Minji Soshō Hō, Tōkyō: Yūhikaku, Dai 6-han, 2018, 262-gen sanshō)

[56] 伊藤眞, (12), 261. (Itō Makoto, (12), 261-gen).

[57] 王亚新, 陈杭平, 刘君博, 『中国民事诉讼法重点讲义』 (第二版), 298頁. (Wang Yaxin, Chen Hangping, Liu Junbo, Zhōngguó Mínhì Sùsòng Fǎ Zhòngdiǎn Jiǎngyì (Dì èr bǎn), 298-gen).

[58] 王亚新, 陈杭平, 刘君博, 『中国民事诉讼法重点讲义』 (第二版), 299頁. (Wang Yaxin, Chen Hangping, Liu Junbo, Zhōngguó Mínhì Sùsòng Fǎ Zhòngdiǎn Jiǎngyì (Dì èr bǎn), 299-gen).

[59] 中华人民共和国民事诉讼法第150条, [http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm) (Сүүлд үзсэн: 2022.11.09).

[60] 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释第五十五条

[61] 中华人民共和国民事诉讼法第二百五十六条  
[http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm) (Сүүлд үзсэн: 2025.12.09).

[62] 中华人民共和国民事诉讼法第二百五十八条 [http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content\\_2024892.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/npc/xinwen/2017-06/29/content_2024892.htm) (Сүүлд үзсэн: 2025.12.09).

[63] 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释第四百七十五条 条

[https://www.spp.gov.cn/spp/flfg/sfjs/201502/t20150205\\_90222.shtml](https://www.spp.gov.cn/spp/flfg/sfjs/201502/t20150205_90222.shtml) (Сүүлд үзсэн: 2025.12.09).





## ДУГНЭЛТ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл буюу Маргаантай эрх зүйн харилцааны зохигчийн аль нэг нь уг эрх зүйн маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн/ бол шүүх тэрхүү зохигчийг сонирхогч этгээд буюу эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлах ажиллагаа нь ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1-ээр хэргийг түдгэлзүүлж , тус хуулийн 133 дугаар зүйлийн дагуу “Онцгой ажиллагааны журам”-аар хэргийг шийдвэрлэгддэгээрээ онцлогтой юм. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдоос бусад буюу гуравдагч этгээдээс болох шүүхээс эрх зүйн үйл баримтыг тогтоож өгөхийг хүсдэгээрээ ялгаатай юм. Харин хэргийг түдгэлзүүлэх ажиллагааны хүрээнд Монгол улсын эрх зүйн тогтолцоонд хэргийг түдгэлзүүлэх хугацааг нарийн зааж өгөөгүй явдал нь хэрэг удаашрах, цаашлаад бусад зохигчдын цаг хугацаа, шүүхчийн шийдвэрлэх хэргийг сунжруулах үндэслэл болж байгаа юм. Түүнчлэн, эрх залгамжлан авах явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гүйцэтгэгдэж болдог ба эрх залгамжлагч хэрэг маргаанаас гарсан этгээдийн бүх эрх, үүргүүдийг эдэлнэ хэмээн тусгаж өгсөн.

Эдгээр эдлэх эрх, үүргүүд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 25 дугаар зүйлд заасан эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах гэх мэт процессын эрхүүд байдаг бол залгамжлах авах үүргийн хувьд шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах, шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх, шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх суурь үүргүүдийг биелүүлэх хэрэгтэй болдог ба процессын эрхийн хүрээнд процессын хуулийн 25 дугаар зүйлд захирагдаад явдаг бол материаллаг эрх зүйн хүрээнд тухайн маргааны төрлөөсөө хамааран зохигч өмнөх эрх залгамжлагчийн эдлэж байсан эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх, гэрээ, хэлцлээс үүдэлтэй шаардах эрх, хохирол, гэм хорыг арилгуулахыг шаардах эрх гэх зэрэг 7 үндсэн суурь эрх үүргүүдтэй.

Түүнчлэн, эрх залгамжлагчийн эдлэх эрх, үүргүүдийн тусламжтайгаар ойролцоо ойлголт болох өв залгамжлах ойлголтоос ялган тайлбарлах боломжтой ба өв залгамжлах

ойлголт нь шүүх дээр маргаан үүссэн эсэхээс үл хамааран иргэнийг нас барснаар өв нээгдэж, харилцаа эхэлж зөвхөн иргэн нас барсан эсвэл нас барсанд тооцогдсон тохиолдолд өв залгамжлал үүсдэг бол эрх залгамжлах ойлголт нь иргэн нас барахаас гадна хуулийн этгээд татан буугдах, өөрчлөн байгуулагдах, эсвэл шаардлага ба үүрэг бусдад шилжихэд үүсэж, заавал шүүх дээр иргэний хэрэг үүссэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх үед явагддаг. Нас барсан иргэний эд хөрөнгө, эдийн болон эдийн бус баялгийн эрх, үүрэг өв залгамжлалаар өвлөгддөг бол шүүх дээр хянан шийдвэрлэглэж буй тодорхой иргэний зохигчийн процессын эрх, үүрэг эрх залгамжлалаар шилждэг ялгаатай. Харин тус процессын хуулийн 28 дугаар буюу нэхэмжлэгч, хариуцагчийг солих ойлголт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө нэхэмжлэгч эсвэл шүүгч хамааралгүй этгээдийг нэхэмжлэгч эсвэл хариуцагчаар татсан байдагаараа эрх залгамжлах ажиллагаанаас ялгаатай юм.

Судалгааны хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад эрх залгамжлах ажиллагаа явуулах нь зохигчид болон шүүхэд хэрхэн нөлөөлдөг, практикийн хүрээнд ямар асуудлууд тулгардаг талаар гүнзгий судлахын тулд Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргын шүүхийн нийт 14 шүүгчийн туслахуудаас эрх залгамжлах ажиллагаатай холбоо бүхий 9 асуулт, 1 задгай асуулт асуумжийн судалгааны аргын хүрээнд авсан ба үр дүнд нь эрх залгамжлалтай холбоотой хамгийн их тохиолддог практик бэрхшээл нь өв залгамжлагч, эрх залгамжлагчийг тодорхойлох, баримтжуулах хүндрэл байлаа. Сураггүй алга болсонд тооцогдсон (50%) болон хуулийн этгээд татан буугдсан (татан буулгах комиссын статус тодорхойлох 50%) тохиолдолд эрх залгамжлагч асран хамгаалагч, төлөөлөгч-ийг тодорхойлох ажиллагаа хамгийн их хүндрэлтэй байгаа нь ИХШХШТХ 30.1-ийн практик хэрэгжилтийг удаашруулж байгааг харуулж байсан. Иргэдэд эрх залгамжлал, шаардлагатай баримт бичиг, материаллаг эрх зүй процессын эрх зүй ялгаа зэрэг мэдээллийг хүртээмжтэй өгөхгүй байгаа нь практикт гол бэрхшээл болж, шүүхийн ажиллагааг удаашруулж байгааг судалгаанд оролцогчдын саналыг баталж байна. Товчхондоо, эрх залгамжлал нь хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд маш бага зохицуулалттай, тусгайлан нөхцөлүүд дээр хэргийн зохигчдын эрх ашгийг хамгаалах шүүхийн оролцоог хангалттай тусгаж өгөөгүйгээс материаллаг эрх зүйн зохицуулалт дутмаг болж үүсэж байна. Үүнээс шүүхийн шуурхай байдал, иргэдийн эрх ашгийг хамгаалахад сөргөөр нөлөөлж байгааг судалгаа тодорхой харуулсан. Үүнтэй зэрэгцэн, 2016 оноос 2025 оныг хүртэл Иргэний болон захиргааны хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхүүдийн шийдвэрлэсэн 8 хэргийг шүүхийн цахим сангаас шүүж эрх залгамжлах голчилох шалтгаан нь зохигч хэргээс гарсан буюу нас барсан тохиолдол

байгаа бөгөөд шүүх хуулийг хэрэглэхдээ ИХШХШТХ-ийн 30.1, 117, эдгээр заалтуудыг хавсаран хэрэглэж байсан нь харагдсан. Үүнд эрх залгамжлах ажиллагаатай холбоотой хөөн хэлэлцэх хугацаа, нэхэмжлэл гаргахаас өмнө нас барсан иргэнийг төлөөлөх, эрх залгамжлагчийн хариуцлага нь хариуцагчийн хүлээсэн үүргийн хэмжээнд, тусгайлсан гэрээгээр хязгаарлагдах зэрэг нарийн хуулиар тусгагдаагүй ойлголтууд илэрж шүүх болон зохигчдын хооронд үл ойлголцол дагуулж байх дүгнэлтэд хүрсэн.

АНУ, Япон улс, БНСУ, БНХАУ нарыг буюу Англо-Саксон, Ром-Германы эрх зүйн бүлийн улсуудаас иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад эрх залгамжлах ажиллагааны талаар харьцуулсан судалгаа хийхэд Англи Саксон эрх зүйн бүлийн улсад (АНУ) эрх залгамжлах ажиллагаа Federal Rules of Civil Procedure-ийн Rule 25-д заасны дагуу зохигч нас барсан, сураггүй алга болсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага/үүргээ шилжүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэрээр хурдан бөгөөд универсал шинжтэйгээр шийдвэрлэгддэг болохыг тогтоов. Ром-Германы эрх зүйн бүлийн улсуудад (Япон, БНСУ, БНХАУ) иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад эрх залгамжлалыг материаллаг эрх зүйн үндэслэлээр (Иргэний хуулийн холбогдох заалтуудтай уялдуулан) зохицуулдаг бөгөөд процессын тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн байдаг нь Монголын ИХШХШТХ-ийн 30 дугаар зүйлтэй төстэй байна. Харьцуулалтаас харахад Монгол Улсын эрх зүйн зохицуулалт нь Ром-Германы тогтолцоонд илүү ойр байгаа ч практикт баримтжуулалт, статус тодорхойлох, материаллаг ба процессын эрх зүйн ялгааг зөв ангилж чадахгүй байх асуудал ноцтой илэрч байгаа тул Монгол улс ч мөн нас барсан, сураггүй алга болсон, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд шүүхийн шуурхай байдлын төлөө хэрэг түдгэлзүүлэх хугацааг АНУ шиг тодорхой зааж өгсөн, болж болохыг харуулж байна.

## ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Манай улсад зохигч нас барахад өвлөх эрхийн гэрчилгээ гарах хүртэл (6 сараас 1 жил) хэргийг хугацаагүй түдгэлзүүлдэг нь хэргийн нөгөө талыг илтэд хохироож, шүүхийн бүтээмжийг бууруулдаг. АНУ-ын жишгээр нас барсан тухай мэдэгдлийг шүүхэд гаргаснаас хойш эрх залгамжлагчийг хэрэгт оруулах 90-ээс 120 хоногийн хатуу хугацааг хуульчлах санал.
2. Хуулийн этгээд татан буугдсан ч эрх залгамжлагч тогтоогдоогүй тохиолдолд хэргийг шууд хэрэгсэхгүй болгодог зохицуулалтыг уян хатан болгох. Татан буулгах комиссын хүлээх хариуцлага, шүүхийн шатанд байгаа нэхэмжлэлийг татан буулгах балансад заавал тусгаж шийдвэрлэх процессыг Иргэний хууль болон Компанийн тухай хуультай илүү нарийн уялдуулах шаардлагатай.
3. Өвлөх эрхийн маргаантай эсвэл өвлөгч нь тодорхойгүй байгаа үед хэргийг гацаахгүйн тулд Япон, Солонгосын адил шүүхээс тухайн хэрэгт зориулж "Өвийн сангийн хэрэг эрхлэгч" буюу "Түр төлөөлөгч"-ийг томилон, процессын эрх залгамжлалыг шууд хийж, хэргийг үргэлжлүүлэх механизмыг нэвтрүүлэх хэрэгтэй.
4. Процессын эрх залгамжлалын үеийн хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох эсэх, эрх залгамжлагчийн хүлээх хариуцлагын хязгаарыг (тухайлбал, өвлөн авсан хөрөнгийн хэмжээнээс хэтрэхгүй байх зарчмыг процессын хуульд) илүү тодорхой тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.
5. Шүүхийн төлбөр, өрнөөс зугтах зорилгоор компаниа зориуд татан буулгасан бол АНУ-ын эрх зүйн жишгээр компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийг нь хэрэгт хариуцагчийн эрх залгамжлагчаар татаж, хувийн хөрөнгөөр нь үүрэг гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль болон Компанийн тухай хуультай уялдуулан бий болгох шаардлагатай.
6. Зохиогч нас барсан эсвэл сураггүй алга болсон тохиолдолд эрх залгамжлагчийг тогтоох онцгой ажиллагааны процессыг шүүхээс шуурхай түдгэлзүүлэх хугацааг процессын хуулинд тодорхой тусган чиглүүлж, бусад оролцогчдын цаг хугацаа, эрх ашгийг ил болон далд хэлбэрээр зөрчигдөхөөс хамгаалах.
7. Манай улсад зохигч нас барсан эсвэл компани татан буугдсаныг шүүх хугацаа алдаж мэддэг, эсвэл баримт цуглуулах гэж цаг алддаг. Солонгос, Хятадын туршлагаар Улсын бүртгэлийн ерөнхий газар (иргэний болон хуулийн этгээдийн бүртгэл) болон Шүүхийн мэдээллийн системийг шууд холбож, шүүгч өөрөө

цахимаар лавлагаа авч, эрх залгамжлагчийг шуурхай тогтоодог болох санамж гаргаж байна.

## НОМ ЗҮЙ

### 1.Эрх зүйн эх сурвалж:

- 1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль /шинэчилсэн найруулга/, 2002 он
- 2.Нотариатын тухай хууль 1999 он
- 3.Иргэний хууль, 2002 он
- 4.Иргэний бүртгэлийн хууль, 2018 он
- 5.Компанийн тухай хууль, 2010 он
- 6.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он
- 7.Гэр бүлийн тухай хууль / шинэчилсэн найруулга /, 1999 он

### 2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Улсын дээд шүүх, *ИХШХШтХ-ийн дэлгэрэнгүй тайлбар*, 2008 он
2. 3.Мөнхжаргал, *Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэгдэх эрх зүй*, 2009 он,
3. Шүүхийн судлагааны төв, *ИХШХШтХ-ийн 30 дугаар зүйлд холбогдох судалгаа*, 2023 он
4. Их Засаг Олон Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, *ИХШХШ эрх зүйн хэрэглээ, дадлага*, 2004 он
5. Хууль зүйн судалгааны хүрээлэн, *ИХШХШ эрх зүй I*, 2001 он
6. Монгол Өмгөөлөл Хууль Зүйн Фирм, “*Шаардах эрхээ шилжүүлэр, өр шилжих зохицуулалтын хэрэгцээ, прогресс /ИХ 123, 124/”*/Өгүүллэг/, 2016 он
7. Монгол улсын дээд шүүх, “*Онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”* /Зөвлөмж/, 2012 он
8. Эрх зүйн цахим хөтөч, “*Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”* /Өгүүллэг/, 2023 он

### 3.Гадаад хэлд дээрх эх сурвалж

#### А. Англи хэлд дээр

#### Б. Япон хэл дээр

**В. Хятад хэл дээр**

## 4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Улсын Хурлын Тамгын газрын цахим хуудас: <https://www.parliament.mn/nn/17671/>.
3. Япон улсын төрийн албаны зөвлөлийн цахим хуудас: <https://www.jinji.go.jp>.

**Монгол хэл дээрх**

1. *Үндэсний статисткийн хороо*. (2024). [www.1212.mn](http://www.1212.mn).

**Гадаад хэл дээрх**

1. Carl Niedbala. (2024). Risk Management: Avoid, Reduce, Transfer or Accept?

**ХАВСРАЛТ**

*Хавсралт А Судалгааны асуулга*